

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА****2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Лхагва гараг****Хуралдааны тэмдэглэлийн агуулга****Хуралдааны товч тэмдэглэл:**

1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

5-32

1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

9-10

13-32

2. Байнгын хорооны тогтоолын төсөл

10-13

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
11 дугаар сарын 19-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 44 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганбат, Да.Цогтбаатар;
Чөлөөтэй: Х.Баттулга, Б.Дэлгэрсайхан, М.Нарантуяа-Нара,
У.Отгонбаяр, П.Сайнзориг, Н.Учрал;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баярмаа, Г.Уянгахишиг;
Тасалсан: Э.Батшугар.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах асуудлыг хойшлуулах, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хэлэлцэх асуудлын дарааллын гуравдугаар асуудал болох Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулах горимын санал гаргаж, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 1

Бүгд: 13

92.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Хууль зүй, дотоод хэргийн амны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Б.Эрдэнэтулга, мөн зөвлөлийн гүйцэтгэх ерөнхий нарийн бичгийн дарга Л.Санжрагчаа, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, мөн Комиссын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Т.Ихтамир, Судалгаа дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал, мөн газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх албаны дарга Ц.Шинэбаяр, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Золбоо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг асуулт асуув.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар уг асуудлыг түр хойшлуулав./11:09/

Хоёр. Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах асуудлыг Улсын Их Хурлын гишүүдийн асуултаар үргэлжлүүлэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, О.Номинчимэг, Х.Баасанжаргал, Х.Тэмүүжин, С.Эрдэнэболд, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад дор дурдсан агуулгатай 4.2.5.5 дахь дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын Үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын чиглэлийн “Дугаар баганад 4.2.5.5” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.2” гэж, “Салбар” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн баганад “Мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлт буурч, иргэдийн хор уршгийн талаарх мэдлэг, боловсрол нэмэгдэж, урьдчилан сэргийлэх зан үйл төлөвшиж, хэрэглэгчдийн тоо мэдэгдэхүйц багасна” гэж, “Арга зам” баганад “Илрүүлэх, шинжилгээний чадавхыг сайжруулж, лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хилийн боомтын хяналт шалгалтыг бэхжүүлж, илрүүлэх төхөөрөмж суурилуулах, хууль бус эргэлтийн мэдээллийн системийг сайжруулж, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай болгох, иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх сурталчилгаа зохион байгуулах, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх.” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам” гэж, 3 дугаар хавсралтын “Үндсэн чиглэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын чиглэлийн дугаар” баганад “4.2.5.5” гэж, “Салбар” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн” баганад “Мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлт буурч, иргэдийн хор уршгийн талаарх мэдлэг, боловсрол нэмэгдэж, урьдчилан сэргийлэх зан үйл төлөвшиж, хэрэглэгчдийн тоо мэдэгдэхүйц багасна” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Тус гэмт хэрэгт холбогдож буй хүний тоо” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин баганад “Он: 2024,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин “баганад 2026:Т-10%, 2027: Т-20%, 2028: Т-30%, 2029: Т-40%, 2030: он Т-50%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын статистик”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 04 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр,

Лхагва гараг

Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”

танхим

10 цаг 44 минут.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмагнайн Баярбаатар, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Даваахүүгийн Пүрэвдаваа, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдийн ирцтэйгээр 52 хувийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр хэлэлцэхээр төлөвлөсөн даргын дэргэдэх зөвлөлөөр орсон 4 асуудал байгаа.

1 дүгээр асуудал. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/ байгаа.

3 дугаар асуудал. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин нарын 20 гишүүн 2025 оны 35 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ асуудал байгаа.

4 дэх асуудал нь Байнгын хорооны тогтоолын төсөл “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” гэсэн ийм 4 асуудал байна.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрээ өгнө үү. Энхбаяр гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Өглөөний амгаланг айлтгая. Энэ манай ажлын хэсэг байгаа юм. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулаад бид нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байгаа. Тэгээд энэ маань арай эцэслэгдээгүй байна. Ойрын үеийн олон хурлууд давхцаад хойшилчихсон учраас энийг хойшлуулж өгөөч гэж хүсэлт гаргаж байгаа.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Өнөөдрийн хэлэлцэх асуудлын 3-д байгаа Тэмүүжин нарын 20 гаруй гишүүдийн санаачилсан Эрүүгийн хуулийн өөрчлөлтийн асуудал бараг сар гаруй өмнө билүү 2 сарын өмнө билүү хойшлуулсан. Бүр өмнөх чуулганаар билүү орж ирээд, тэгээд хойшлуулъя гэж ярьж байсан. Тэгэхэд чинь нэлээн саналууд авъя гэж ярьж байсан билүү. Дээд шүүхийн билүү, бүлгээрээ хэлэлцье гээд хойшлуулж байсан. Дээд шүүхийн санал тараагдаагүй байна. Би Дээд шүүхийн хэлэлцсэн санал байна уу, тараамаар байна энэ тэр гэж байсан. Энэ гишүүдэд тэр Дээд шүүхийн санал нь тараагдсан юм болов уу гэсэн асуудал байгаад байгаа юм. Яах вэ, би гишүүдийнхээ хууль санаачлах эрхэд үргэлж хүндэтгэлтэй ханддаг. Манай мэргэжлийн Байнгын хороо энэ хууль санаачлагчдын оролцоотойгоор, тэгээд ялангуяа энэ судлаачид Улсын дээд шүүх, Засгийн газар, Хууль зүйн яам, прокурор, мөрдөх байгууллагууд гээд нэлээн өргөн хүрээтэй ойрын хугацаанд хэлэлцүүлэг хийчихмээр л санагдаад байгаа юм даа эхлээд. Яагаад би энийг яриад байна вэ гэхээр энэ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн гэмт хэрэг, ял, хариуцлагатай холбоотой суурь ойлголтуудыг нь өөрчилж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ суурь ойлголтууд өөрчлөгдөнө гэдэг бол манай улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоо ял хариуцлагатай холбоотой бүх зүйл анги хөндөгдөөд байгаа юм. Энийг дагасан маш том хэмжээний өөрчлөлт явж байгаа. Хэдийгээр нэмэлт, өөрчлөлт гэдэг нэртэй боловч уг нь бол Эрүүгийн хуулийн суурь ойлголтуудыг өөрчилбөл энэ шинэчилсэн найруулга болчихоод байгаа байхгүй юу. Хэрэг дээрээ Эрүүгийн хуулийг шинээр өргөн барьчихаад байгаа юм. Яг хэрэг дээрээ бол. Тэгээд Эрүүгийн хуулийг шинэчилсэн найруулгын түвшинд ийм үзэл баримтлалын шинжтэй том өөрчлөлтийг бол их л нухацтай, олон талын оролцоо, хэлэлцүүлэгтэй ярихгүй бол болохгүй байгаад байна л даа. Тэгэхгүй энэ их донсолгоо болдог. Өмнө нь Алтанхуяг Ерөнхий сайдыг байхад Тэмүүжин бас Хууль зүйн сайд байхад Эрүү, Эрүүгийн процессын хуулиуд өөрчлөгдөж байна гээд энэ том донсолгоо болоод л олон хуульчид хуульчдын бослого маягийн юм хийгээд, энэ нь том улс төр болоод тэгээд л яваад л байсан байхгүй юу. Тэгээд би нөгөө ярьж байгаа концепцыг одоо гэдэс дотор нь орж зөв, буруугийн тухай ямар нэгэн байр суурь огт илэрхийлэхгүй. Нэлээн ийм хэлэлцүүлэг, тал талын оролцоо мэдээлэл хангаж байж ярихгүй бол мэргэжлийн Байнгын хороо энэ асуудалд бас нухацтай хандах ийм л шаардлага л үүсчхээд байх шиг санагдах юм. Тэгээд ядаж Байнгын хорооныхоо гишүүдийг оролцуулж байгаад хэлэлцүүлэг хийж болохгүй юу Цогтоо дарга аа. Би бол ийм санал гаргах гээд байгаа юм. Тийм учраас ядаж 7, хоёр 7 хоногоор хойшлуулж болохгүй юу. Хууль санаачлагч маань энэ дээр хүлээж авч болохгүй юу л гэсэн ийм горимын санал гаргах гээд байгаа юм.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Байнгын хорооныхоо түвшинд хэлэлцүүлэг хийвэл болж байна уу. Энэ хэлэлцэх эсэхийг нь шийдэх гэж байгаа шүү дээ бид. Тэгээд уг нь хэлэлцэх эсэхээ шийдчихээд хэлэлцүүлэг хийгээд явах бол нээлттэй. Хуулийн төсөл өргөн бариад бараг 1 жил болох гэж байна шүү дээ. Хэлэлцэх эсэхийг нь шийдэх хурал

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

түрүүчийн чуулганаар явсан. Түрүүчийн чуулган дээр Сайнзориг гишүүн бид хоорондоо бүлгээрээ хэлэлцмээр байна гэдэг үндэслэлээр хойшлуулсан.

Суурь шинжтэй том өөрчлөлт бол яг ял шийтгэлийн бодлого дээр байхгүй. Гэхдээ философийн шинжтэй буюу үзэл баримтлалын ойлголтыг жигдлэх шинжтэй өөрчлөлт байгаа. Тэрийг бол хүлээн зөвшөөрөх ёстой. Тухайлбал, Монгол Улсад гэмт хэргийг нийгэмд аюултай шинж чанар, нийгмийн аюулын хэр хэмжээ гэдэг ойлголтоор тодорхойлдог ийм социалист уламжлал байгаа. 2015 оны Эрүүгийн хуулиар энэ дээр судалгаа хийж байгаад хуулийн байгууллагуудтай нэлээн их ярилцаж байгаад энэ ойлголтыг халсан юм. 2017 онд буцаагаад ороод ирчихсэн. Одоо нийт шүүхийн шийдвэрт дурдагдаж байгаа нийгмийн хор аюул, нийгмийн хор аюулын хэр хэмжээг нь үнэлээд, ял оноолоо гэдэг энэ үгийг ашиглаад, ял оноолоо гэдэг шүүхийн шийдвэр бараг 100 хувь байгаа. Энэ үг нь ардаа очоод яг тусгай ангиуд дээр бол байхгүй. Гэтэл бид бодитойгоор ойлгох хэрэгтэй. Нийгмийн аюул эсвэл нийгмийн дэг журам гэх мэт ойлголт эрүүгийн хуулиас бусад хууль дээр бичигдэх аюул биш. Эрүүгийн хууль дээр бичээд хэмжигдэхгүй хийсвэр ийм ойлголтоор хүнийг яллана гэдэг харин энэ өөрөө иргэнийхээ эрхийн хувьд маш том аюул. Нийгэмд учруулсан хор, аюул, нийгэмд аюултай үйлдэл гэдгийг яаж хэмжих юм. Даргыг шүүмжлээд байгаа учраас энэ гэмт хэрэг байна гэж үзэх юм уу. Байнга шүүмжилж хэл ам хийгээд байгаа учраас энэ гэмт хэрэгтэн байна гэж хэлэх юм уу. Эсвэл нийгмийн нийтлэг дүр төрхөөс гаж хувцасласан учраас энэ нийгэмд аюултай этгээд байна гэж үзэх юм уу. Энийг хэмжиж болдоггүй зүйл.

Би зүгээр ганцхан жишээ уншаад өгье та хэдэд. Эрүүгийн хууль дээр. Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн шударга ёсны зарчим гэдэг дээр ингэж бичсэн байгаа юм. Ял, албадлагын арга хэмжээ нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна гэж бичсэн байгаа байхгүй юу. Нийгмийн аюулын шинж чанар гэдгийг яаж хэмжих гэж байгаа юм. Соёлт хүн төрөлхтөн энийг чинь ингэж бичиж байна. Ял, албадлагын арга хэмжээ нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, учруулсан хохирлын хэр хэмжээ гэм буруугийн хэлбэрт тохирсон л гэж бичиж байна. Учруулсан хохирол бол хэмжигдэнэ. Нийгмийн аюулын хэр хэмжээ чинь хэмжигдэхгүй шүү дээ. Ийм субъектив зүйлээр хүнийг ялладаг, энэ нь зөв байна гэж үздэг тогтолцоо бол социализм байсан үнэн. Удирдагчийнхаа нэр хүндийг хамгаалах, улс төрийнхөө тогтолцоог хамгаалахын тулд нийгэмд аюултай гэж хэлж байгаад иргэнээ шийтгэдэг. Энэ жоохон архи уудаг учраас гаднын зочин ирж байна гээд хотоос хөөж гаргадаг ийм зүйл байсан. Тэр бол үнэн. Одоо ардчилсан нийгэмд ийм байж болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ концепцын .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хэлчих. Энэ концепцын философийн зөрүү мөн.

Хоёрт нь дахиад эрүүгийн хариуцлага гэдэг ойлголт байна. Эрүүгийн хууль дээр биччихсэн. “Эрүүгийн хариуцлага нь ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ.” гээд биччихсэн. Тэгэнгүүтээ Эрүүгийн хуулиас гадна энэ зузаан байгаагийн шалтгаан энэ хар даа. Ийм зузаан байгаагийн шалтгаан нь Эрүүгийн хуулиас гадна маш олон хууль дээр эрүүгийн хариуцлага хүлээсэн, хүлээхээр бол гээд иргэний эрхийг хязгаарлачихсан. Ял аваагүй мөртөө албадлагын арга хэмжээ авагдаад, тэгээд иргэнийхээ эрхийг хязгаарлуулж байна шүү дээ. Бусад хуулиар. Жишээ нь жоохон ууртай нийгэм нь ч тэр хүнийг уур бухимдалд их автуулж байна.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Гэр бүл дотроо хүүхдэдээ жоохон ааш гаргачихсан. Тэгэхдээ гэр бүлийн хүчирхийлэл ял авах хэмжээнд биш.

Гэхдээ тэр аавыг уураа барих сургалтад албадан сургана шүү дээ. Тэгсэн чинь уураа барих сургалтад албадан суулгасныхаа төлөө эрүүгийн хариуцлага хүлээсэн гээд өөр нийгмийн харилцаанууд дотор эрхээ хязгаарлуулж байна шүү дээ. Энийг засахгүй юм уу. Энэ чинь бол хавтгайруулан ерөнхий нэр томьёогоор иргэний эрхийг хязгаарлаж, зөрчиж байгаа Үндсэн хуулийн бус үзэгдэл шүү дээ. Тэгэхээр энийгээ бид ярилцаад, шийдэх ёстой. Энийг юу гэдэг юм. Суурь шинжтэй, бараг Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт орох хэмжээний юм боллоо гэж үзэж байвал үгүй шүү дээ. Энэ чинь бусад хууль дээр гэмт хэргийн шинжтэй гэж бичих ёстой зүйл байна. Ял эдэлсэн гэж бичих ёстой зүйл байна. Гэтэл бүгдийг нь эрүүгийн хариуцлага хүлээсэн бол гээд биччихсэн.

Гэтэл Эрүүгийн хууль дээр байгаа албадлагын арга хэмжээ, Зөрчлийн хууль дээр байгаа албадлагын арга хэмжээ чинь нэг шүү дээ. Яг адилхан. Албан тушаалтан иргэн рүү та бол эрүүгийн хариуцлага хүлээх этгээд мөн байна гээд Зөрчлийн хууль дээр байгаа албадлагынхаа хэмжээг бариад, иргэнийг айлгаад, сүрдүүлээд, эрх чөлөөг нь энэ чөлөөт нийгмийн харилцаан дотор хязгаарлаж байна шүү дээ. Тэгэхээр бид энийг засах ёстой. Байнгын ийм диктатур, байнгын ийм төрийн .../минут дуусав/

Б.Цогтбаатар: Би сая байр сууриудыг сонслоо. Энэ дээр Тэмүүжин гишүүн ээ ингэмээр байна. Би таны байр суурийг дэмжээд, даргын дэргэдэх зөвлөл дээр оруулъя гэсэн шүү дээ. Тэгэхдээ хэдүүлээ энэ дээр 3 үндэслэлээр ер нь Байнгын хорооныхоо түвшинд энийгээ дахиж яриад, оруулж ирэх санал тавих гэж байна. Яагаад гэвэл ийм асуудал байна. Надад бол 3 үндэслэл байна.

Нэгдүгээрт, хариуцсан сайд гэдэг бид нар бас үгийг нь сонсохгүй бол болохгүй. Энэ дээр байр суурь түрүүний удаа ч зөрүүтэй байж байсан. Энэ үгээ ч нэлээн хатуу хэлж байсан. Энэ үгээ хэлээд байна. Яагаад гэвэл энэ ёстой хэдүүлээ сууж байж ярих ёстой асуудал.

Хоёрт нь нөгөө тэр үед хойшлуулдаг чинь бүлгээрээ хэлэлцүүлье гэсэн шүү дээ. Тэгээд нөгөө юун бүлгээрээ энэ асуудал хэлэлцэх манатай л юм болоод явчихлаа шүү дээ. Одоо бодит улс төрийн нөхцөл байдал чинь. Тэгээд бүлгээрээ хэлэлцээгүй байгаа. Нөгөө нөхцөл нь бүрдээгүй байгаа байхгүй юу. Тэгээд яваагүй л байна. Яг үнэнээ л хэлье .

Хоёрдугаарт, яг философийн талаас наадах чинь суурь өөрчлөлт. Одоо би нөгөө санал болгож байгаа юмнуудыг чинь харахаар ийм байна. Хэдүүлээ ярихгүй яагаад болохооргүй байна гэхээр яг үнэн. Энэ дээр Энхбаяр гишүүний хэлж байгаа тэр суурь өөрчлөлтийн шинж чанартай юм байгаа. Таны энийг ингээд авчихаар тэр Criminal liability буюу энэ strafrechtliche ... гээд Герман дээр. Бас криминал ... гээд тэр ухагдахуун өөрөө алга болох гэж байгаа юм шиг харагдаад байгаа юм. Би бүрэн гүйцэт өөрөө итгэл үнэмшлээ олж авч чадахгүй байгаа.

Таны хэлж байгаа яг үнэн. Хариуцлага хүлээсэн гээд шал өөр юман дээр хүмүүст хариуцлага хүлээлгээд байгаа, эсвэл иргэний өөр харилцаа дээр сөрөг үр дагавар иргэн дээр сөргөөр тусаж гарч байгаа бол энийг засах ёстой. Би санал нэг байна. Гэхдээ энийгээ хэдүүлээ эргэж ярихгүй бол нөгөө эрүүгийн хариуцлагын

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

асуудал чинь ял бол шүүхийн шийдвэр гарснаас хойш ялын асуудал гарч ирж байгаа. Эрүүгийн хариуцлага бол хийгээгүй байхад ч гэсэн та ийм үйлдэл хийвэл хариуцлага биш яг тэр дээр ямар ял байх нь тодорхой биш. Гэхдээ хариуцлагатай шүү гэдэг тэр эрх зүйн ойлголт өөрөө хуулиас ерөөсөө алга болж болохгүй шүү дээ. Тэгэхээр тэр талаасаа хэдүүлээ бодолцоод, энэ удаадаа хойшлуулъя гэдэг санал хураалгамаар байна.

Алтанхуяг гишүүний үгээр бол нэгэнт санал оруулж ирж байгаа хүн өөрөө нөгөө ажлын хэсэг маань бас хуралдаж амжаагүй байгаа бол энийг бас хойшлуулъя гэдгээр санал хураалт явуулъя. Ингээд 2 асуудлаар санал хураалт явуулъя. Тэгээд буцаад орж ирнэ гэсэн үг шүү дээ. Наадахыг чинь бас хэдүүлээ тараацаагай тэгэх үү.

1 дүгээр асуудал энэ хэлэлцэх асуудлын 2-т байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Үндсэн хуулийн 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг хойшлуулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Хойшлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Манайхан уучлаарай. Байж байгаарай. Манайхан санал хураалтдаа бэлдээрэй. Бэлдсэн үү манайхан. Санал хураалт. 92,3 хувиар санал дэмжигдлээ.

Энэ хэлэлцэх асуудлын 3-д байгаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин нарын 20 гишүүн 2025 оны 5 дугаар сарын 30-нд өргөн мэдүүлсэн энэ хуулийн төслийг хойшлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

“Монгол Улсын Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Энэ нөгөө Байнгын хороонд орчихсон суугаад байдаг. Ажлын хэсгээс хүмүүс зарим нь бас нөгөө Байнгын хороонд орчихсон байгаад байгаа юм байна. Ямар ч гэсэн энэ ирцэд ирж байгаа хүмүүсийг танилцуулъя. Ажлын хэсгийн нэрс. Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Энхбаярын Батшугар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Лхагважавын Мөнхтүшиг Гадаадын харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чулуунбор Гандирваа Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Чулуунцэцэгийн Золбаяр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Санжаагийн Наранцогт. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Золбоо Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын дарга .

Энэ ажлын хэсэг чинь тэгээд байхгүй байхад яах юм бэ. Манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Эрдэнэтуяа Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Санжрагчаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн Захиргаа удирдлагын газрын дарга, Хүний эрхийн Үндэсний Комисс Энхболд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Ихтамир Хүний эрхийн Үндэсний Комиссын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Тунгалагтамир Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга, Азжаргал Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар, Шинэбаяр Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх албаны дарга, Улсын ерөнхий прокурорын газар Чинбат Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Гансэлэм Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй манай салбарын төлөөлөл оролцож байна.

Ингээд Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал энийг хамтатгаад явуулчихъя. Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Номинчимэг гишүүнээр, Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Таван жилийн төлөвлөгөө байгаа биз дээ. Надад 1 л асуулт байна. Хэдүүлээ 2050 он хүртэл хөгжүүлээд алаад өгнө гээд л баахан юм ярилаа. Одоо 5, 5 жилээр нь төлөвлөөд л алаад өгнө гээд баахан юм ярих юм. Шууд үгүйсгэх нь хаашаа ч юм. Тэгэхдээ ажлаа хиймээр байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, надад ганцхан асуулт байгаа. 5 жилийн дараа монголчуудын амьдрал ямар болох юм бэ. Баахан арга хэмжээ аваад л байна. Ажил хийгээд л байна. Улсаа хөгжүүлнэ гээд л байна. Хулгай дээрэм нь дийлдэхгүй юм. Тэр хэрүүлийг би орхичихъё. Ер нь энэ 5 жилийн төлөвлөгөөний дараа Монгол хүний ахуй амьжиргаа өнөөдөр ямар болчихоод байгаа юм бэ. 3 хүний 2 нь бараг ядуу байгаад байгаа юм. Ямархуу болох юм. Хэмжих нэгж гэж юм байна уу. Хэн хариулах вэ. Энд хариулт аваадахъя. Та нар ард түмэнд ч гэсэн их тодорхой хэлээдхээч. Бид нар энэ таван жил ингэж ажиллаад, ийм мундаг юмнууд хийгээд, тэгээд ийм юманд хүрэх гэж зорьж байгаа хүрч, чадна гэдэгт итгэлтэй байгаа гээд яг тоо хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Үгүй ээ, үгүй. Энэ сайд нар нь орж ирээд хариултаа өгөх ёстой л доо. Сайд нарыг орж иртэл асуудлыг хойшлууллаа.

11.09 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Байнгын хорооны тогтоолын төслийн асуудал байж байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлнэ. Байнгын хорооны тогтоолын төслийн талаарх танилцуулгыг би өөрөө уншаад танилцуулчихъя.

Төв банк Монголбанкны тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар Хяналтын зөвлөл нь Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц, мөн Монгол банкнаас Улсын Их Хурал болон олон нийтэд санхүүгийн тайлангаа тайлагнаж, мэдээлж байгаа байдлыг хянах Монголбанкны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих чиг үүрэгтэй. Өөрөөр хэлбэл хяналтын зөвлөл нь Монголбанкны үйл ажиллагаанд хяналт тавьж, хараат бус байдлыг хангах үүрэгтэй бөгөөд нийтийн эрх ашигт үйлчилдэг.

Үүний тулд хуульд заасан шалгуур бүхий албан тушаалтны хувьд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг хуулийн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэн Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор Байнгын хорооны 2024 оны журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай 5 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж ХОМ гаргах албан тушаалтны жагсаалтад Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг нэмсэн.

Гэвч 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас томилсон Хяналтын зөвлөлийн дарга, гишүүний нэр дэвшүүлэх үйл ажиллагаа нь 2024 оны 12 дугаар сарын 5-нд эхэлсэн бөгөөд Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр тогтоол гарахаас өмнө явагдаж эхэлсэн.

Тодруулбал, Хууль зүйн байнгын хорооны журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай тогтоолд нэмэлт оруулах тухай тогтоол батлахаас өмнө Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавих болзол, шаардлагад нийтийн албан тушаалтанд хамрагдах давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хориглолт зэрэг нь тусгагдаагүй байсан бөгөөд нэр дэвшигчид тухайн үед хуульд заасан болзол шаардлагыг ханган нэр дэвшигчийн сонголд оролцож, Улсын Их Хурлаас томилогдсон байна.

Дээр дурдсан асуудлаар Монголбанкны хяналтын зөвлөлөөс Хууль зүйн байнгын хороонд хүсэлт гаргах тухай 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 27 тоот албан бичиг ирүүлснийг Байнгын хороо хүлээн авч, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Авлигатай тэмцэх газраас санал авахаар холбогдох албан бичгийг хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газар 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр уг асуудлын талаар тусгай өгөх саналгүй талаар хариу хүргүүлэх тухай албан бичгийг Хууль зүйн байнгын хороонд ирүүлсэн.

Иймд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооны 2024 оны журам маягт, жагсаалт шинэчлэн батлах

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тухай 5 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар батлагдсан мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтад 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас томилогдсон Монгол банкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүд хамаарахгүй байхаар Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр тогтоолтой холбогдуулан авах арга хэмжээний тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хороогоор шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ. Энэ тогтоолыг 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас томилогдсон Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэлх хугацаанд дагаж мөрдөх бөгөөд шинээр томилогдох банкны Хяналтын зөвлөлийн дарга гишүүдэд уг тогтоол нь хамрахгүй юм.

Ингээд Байнгын хяналтын зөвлөлтэй холбогдсон танилцуулгыг уншиж танилцууллаа. Байнгын хорооны төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Соронзонболд гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Энэ Монголбанкны Хяналтын зөвлөлтэй яг адилхан нөхцөл байдалтай өөр ийм Авлигатай тэмцэх газарт мэдээллээ өгөх шаардлагатай албан тушаалтнууд байгаа юу. Өөр байгууллага дээр гэсэн үг шүү дээ. Зөвхөн Монголбанкны хяналтын зөвлөлийг тусад нь ганцааранг нь ярилцаад байна.

Д.Цогтбаатар: Одоогийн байдлаар бидэнд тийм мэдээлэл байхгүй байна. Одоо энэ чинь яг яах аргагүй бид нар нөгөө журам гаргаад, үүний дараа хэрэгжээд эхлэнгүүт амьдрал дээр яг энэ хяналтын хорооныхон бол угаасаа манай журам чинь яг үүнтэй холбогдож гарсан. Үүнийхээ дагуу энэ чинь бид нарыг өргөдлөө өгөхөд ийм журам байгаагүй. Тэгээд одоо энэ журам шууд ингээд үйлчлүүлээд эхэлж байна гэдэг өргөдлөө л Хяналтын зөвлөлөөс нь ирүүлсэн юм. Өөр бидэнд тийм мэдээлэл байхгүй байна.

Тэгвэл энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Тэмүүжин гишүүнээр тасалъя. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Энэ Монголбанкны захирал нь болохоор нийтийн албан тушаалтан ХОМ гаргадаг албан тушаалтанд ордоггүй гэсэн үг үү. Зөвхөн Хяналтын зөвлөл. Тэгэхдээ Монголбанкны өөрийнх нь үндсэн удирдлага нь яадаг юм. Бас ордоггүй гэсэн үг болж таарах гээд байна шүү дээ.

Д.Цогтбаатар: ХОМ өгдөг. Энэ чинь нөгөө орон тооны бус хяналтын зөвлөл нь байхгүй юу. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Тэгвэл энэ дээр би 1 зүйлийг хэлчихье. Яг түрүүн Тэмүүжин гишүүнтэй яг ярьсан. Одоо ингээд онолын асуудлууд үнэхээр амьдрал дээр гарч ирж байна. Одоо энэ яг амьдрал дээр гараад ирж байгаа асуудал. Бид нар энэ тогтоолыг батлахад тэрнээс сарын өмнө энэ орон тооны бус зөвлөлийн гишүүд өөрсдөө өргөдлөө өгчихсөн байсан. Тэгээд энэ чинь орон тооны бус зүгээр л урамшуулал авдаг юм байна. Тэгсэн Тэмүүжин гишүүн энэ дээр бид нар ёстой бодохгүй бол энэ хүмүүс хувийн салбарынхаа нөгөө хяналтын зөвлөл орон тооны бус зөвлөл болохоор хувийн салбарын төлөөлөл орж ирж байгаа байхгүй юу. Тэгсэн нөгөөдхийг нь ХОМ бөглүүлдэг болонгуут ганцхан шалгуураар тэрийг нийтийн албан тушаалтан болгоод, тэгэнгүүт нөгөө хүмүүс чинь өөрийн эрхгүй өөрийн

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

эрхэлж байгаа хувийн ажлаасаа гарах болж байгаа байхгүй юу. Орон тооны бус ажлыг 4 жил урамшуулалтай хийх гэсэн чинь хамаагүй өндөр цалинтай нөгөө ажлаасаа татгалзах хэрэгтэй нөхцөл байдал руу орчихсон. Тэгээд энийг чинь яг эрх зүйн үүднээсээ ч гэсэн бид нар нөгөө сүүлдэж гарсан болохоор процесс нь эхлээд эхэлчихсэн юмыг буцааж хэрэглэж угаасаа болохгүй. Тийм учраас энэ удаагийнх нь хүмүүст чөлөөлж өгье гэж байгаа. Цаашдаа энэ нийтийн албан тушаалтныхаа тодорхойлолтыг ч бид нар харахгүй бол энэ чинь байхгүй юм байна шүү. Тэгээд энэ дээр бас бодох ёстой юм байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд бэлтгээ санал хураалтад. Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 85,7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

11.18 цаг

Ингэе. Үндсэн чиглэлийн асуудлаа хэдүүлээ буцаагаад хэлэлцэж эхэлье.

Нөгөө Байнгын хороо дээр асуулт, хариулт нь дууслаа гэж байна. Тэгэхээр одоо ажлын хэсэгт түрүүн дурдагдсан хүмүүс нь орж ирэх ёстой. Урья. Энэ байнгын хорооны ажлын албаныхан энэ дээр ажиллаарай. Хүмүүсээ оруулж ирээрэй.

Нөгөө түрүүн манай асуулт асуусан Алтанхуяг гишүүн байж байгаа юм. Орж ирээд өөрөө асуултаа ахиад асуугаад яваг. Тэгээд хэдүүлээ яриад явъя. Ерөнхий асуулт асуусан. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Дахиад асуух юм уу. Бямбацогт сайд аа, би их тодорхой асуулт асуугаад байгаа юм. Бид нар энэ 5, 5 жилийн төлөвлөгөө гаргаад, баахан төлөвлөгөө л ярьдаг боллоо. Ажлын гүйцэтгэл олигтой яригдахгүй. Ард түмний ахуй амьжиргаа гэдэг юм уу, аж ахуйн нэгжүүд дээр бодитой ахиц дэвшил гарахгүй өчнөөн олон жил алдаад байна. 5 жилээр нь хөгжүүлээд алаад өгнө. 2050 он гэхэд ингэнэ гээд л баахан юм ярьцгаагаад байх юм. Тэгэхээр би ямар тодорхой асуулт асууж байгаа вэ гэхээр энэ 5 жилийн төлөвлөгөө хэрэгжлээ гэж бодоход яг ард түмний ахуй амьжиргаа дээр аж ахуйн нэгжүүдийн хувьд ямар ахиц дэвшил гарах юм бэ. Тоо хэмжигдэхээр юм байна уу. Байхгүй юу. Ийм л асуулт асуусан юм.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Бид нар 1990 он хүртэл үндсэндээ төлөвлөгөөтэй, тав таван жилээр нь төлөвлөөд, тэгээд тэрнийхээ үнэлэлтийг, биелэлтийг гаргаад ингээд нэлээд тогтчихсон 1950-иад оноос хойш бараг 40-өөд жил байх. Та их сайн мэдэж байгаа Алтанхуяг гишүүн. Явж ирсэн. 1990 оноос хойш үндсэндээ төлөвлөлтгүй болсон. Төлөвлөлт гэдэг зүйлийг үндсэндээ бараг буруу юм шиг ойлгодог, хардаг болсон. Ингээд 1990-2020 он хүртэл 30 жил төлөвлөгөөгүй явсан. Төлөвлөлт байхгүй. Төлөвлөлт байхгүй

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

болохоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх энэ асуудлууд маань эрсдэлтэй. Ялсан нам болгон өөрийн Засгийн газрын бодлого хэрэгжүүлнэ гэдэг. Ерөнхий сайд болсон хүн болгон өөрсдөө би өөрийнхөө бодлого явуулна. Өмнөх Ерөнхий сайдын Ерөнхий сайдын явуулж байсан бодлого надад хамаагүй гэдэг. Үүнээсээ болоод доороо хий эргэсэн, тэгээд бие биеэ үгүйсгэсэн иймэрхүү байдалтай явж ирсэн. Бас дахиад үүнийх нь үр дагавар нь үүнээсээ болоод төр бодлогогүй, төрийн бодлого тодорхой биш, тогтвортой биш болохоороо нөгөө Засгийн газар 1 жил 6 сарын настай байгаад байдаг болсон.

Үүнийг засах гэж 2019 онд бид нар Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт хийсэн. Монгол төрийн бодлого тодорхой байна. Тогтвортой байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэсэн хуулийг Үндсэн хуульд оруулаад, 2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулаад, 2021 оноос 2025 он хүртэл 5 жилийн үндсэн чиглэл буюу 5 жилийн төлөвлөгөө гэж баталсан. Энэ 30 жил тасарсан асуудлыг шийдээд явж байхад анхны байсан учраас тэр үед бол тодорхой бодлогоо, зорилтоо дэвшүүлсэн. Түүндээ хүрэх үр дүнгээ тооцсон. Энийг бас биелэлтийг нь гаргаад 9 сард Засгийн газарт хүргүүлсэн байгаа. Одоо 5 жилийн үндсэн чиглэлийн. 2021-2025 оны. Энэ дээрээсээ бас дүгнэлт хийж байгаад, Эдийн засаг, хөгжлийн яам 2026-2030 оныхоо үндсэн чиглэл, 5 жилийнхээ төлөвлөгөөг ингэж төлөвлөө. Ингэж зорилтуудаа боловсруулж тавья. Энэ байгаа түвшнээ ингэж үнэлье. Хүрэх түвшнээ ингэж гаргаж ирье гэдгийг маш тодорхой болгож оруулж өгсөн. Ингээд энэ хэмжих үзүүлэлтүүдийн хүрээнд 8 чиглэлийн хүрээнд үндсэн 10 үр дүнд хүрэхээр тодорхойлсон байгаа.

Энд Нэгдүгээрт нь, боловсрол, эрүүл мэндийн салбарт хийх шинэчлэлийн хүрээнд чанартай, хүртээмжтэй, иргэн бүрд тэгш хүргэж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийг бэлтгэж, хүний хөгжлийн үзүүлэлтийн индексийг 0,813-д хүргэнэ. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, ажлын байран дахь осол гэмтэл, хөдөлмөрлөх эрхийн зөрчил маргааныг бууруулах замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлнэ. Өнөөдөр бас 1 хүнд ноогдох дотоодын нийт .../минут дуусав/

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Бямбацогт сайд аа, Засгийн зовлон, жаргалыг би ойлгож байгаа. Тэгэхдээ одоо ингээд худлаа пан гөрөхөө болимоор байна шүү дээ. Одоо бид нар энэ Их Хурал дээр ингээд суугаад баахан л төлөвлөгөө яриад, тэгснээ биелэлтийг нь цаасаар хүргүүлсэн гээд цаас хийгээд үйлдвэрлээд энд юм яриад амьдрал сайжирдаг бол болж л байна л даа. Наадах төлөвлөгөө чинь хэрэгжээд, энэ олон хуудас цаас уншаад, яриад, тэгээд 7 буудлын Должин эмээгийн амьдрал яаж сайжрах юм. Энэ аж ахуйн нэгжүүд сөхөрчихсөн, татвараа төлж дийлэхгүй байгаа аж ахуйн нэгжүүд, нийгмийн даатгалын шимтгэл гээд байгаа энэ нөхдийн юман дээр ямар өөрчлөлт гарах юм бэ. Яг энд л хариулт авъя гэсэн шүү дээ.

Түүнээс биш та орж ирээд наадах өрөөсөн хэсгийг нь уншаад энэ тэр 0,3-ыг хэн ч ойлгохгүй. Ер нь ингэж юу гэдэг юм, хуучирсан арга барилаар ингэж ажиллахаа болимоор л юм даа. Төлөвлөгөөг би буруу гээгүй байна.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

О.Номинчимэг: Уг нь Хууль зүйн сайдаас бас асуумаар байгаа юм. Хууль зүйн сайд байхгүй байна. Дуудаад өгөөрэй. 2 асуулт байгаа.

Хэрэг эрхлэхийн дарга байгаа учраас Хэрэг эрхлэхийн даргатай холбоотойгоор энэ төрийн өмчит компаниудтай холбоотой бас зорилт, 5 жилийн төлөвлөгөөнд орж ирсэн. Тэгээд ер нь яах вэ, энэ 5 жилийн төлөвлөгөө, Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр гээд баахан цаас бичиг бид нар үйлдвэрлээд л байна. Хоорондоо нийцэл нь ямар ч байгаа юм. Яг энэ гишүүдтэй уг нь санал 1 байгаа. Гэхдээ нэгэнт бид нар энийг хэлэлцэж байгаа бол би өмнө чуулган дээр төрийн өмчит компанийн тухай асуусан. Төсвөөс гадуурх баялаг хуваарилалтын хамгийн том хэрэгсэл болоод, энэ маань өөрөө энэ зах зээлийн гажуудлыг үүсгэдэг, авлигын үүр уурхай болж байгааг хэлээд, энэ төрийн өмчит компаниудаа ер нь цэгцлэх асуудлыг нэн даруй, яаравчлах хэрэгтэй байна. Энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд заавал хийх ёстой байна гэдгийг хэлсэн. Энэ дээр бас тийм тодорхой хариулт авч чадаагүй.

Тэгээд өнөөдөр ингээд харахаар шалгуур үзүүлэлтүүдийг харахаар ер нь төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ гээд шалгуур үзүүлэлтүүд нь процентоор тооцсон ч юм шиг. Ил тод байдал гээд юм яг шалгуур үзүүлэлтүүдийг нь бас харахад учир дутагдалтай. Тэгэхээр яг 5 жилийн хугацаанд одоо энэ Засгийн газар газрын хувьд мэдээж дахиад 2,5 жил, 3 жил орчим хугацаа байгаа. Энэ хугацаа ихэнх нь шүү дээ 5 жилийн энэ төлөвлөгөөний чинь. Тэгэхээр төрийн өмчит компаниудыг цэгцлэх асуудал дээр, ер нь зах зээлээ бид нар төрийн өмч, төрийн оролцоог багасгаад, хувийн өмчийн, бизнесийн орон зайг нь боомилоод байгаа энэ асуудлыг шийдэх асуудал дээр, энэ засаглалыг нь илүү хариуцлагатай болгох асуудал дээр Засгийн газраас ямар бодлого, төлөвлөгөө хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа вэ. 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан байсан шүү дээ. Зардлыг нь багасгаад бүр тоотой 30 хувь, 15 хувь. Тэгээд энэ болохоор энэ 5 жилийн төлөвлөгөөнд чинь болохоор шал өөр юм орж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энэ дээр яг бодлого юу барьж байна гэдгийг нэгдүгээрт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хариулаад өгөөч.

Хоёрдугаарт, Хууль зүйн сайдаас асуумаар байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой 2, 3 шалгуур үзүүлэлт, зорилтууд орж ирсэн байна. Тэгээд ихэвчлэн тэр хоригдож байгаа хүмүүсийн цалин хөдөлмөртэй болгоё. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг сайжруулъя гээд жилд 1 хувийн өсөлттэй байхаар. Тэгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр хамгийн угаасаа тулгамдаж байгаа асуудал бол захиргааны болон иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл байгаа. Маш бага хувьтай. Тэгээд энэ дээр ямар шинэчлэлийг та бас хийхээр ажиллаж байна. Уг нь Алтангэрэл сайд байхдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай нөгөө багц хууль өргөн барьчихсан. Одоо хүртэл Улсын Их Хурлаар хэлэлцэгдээгүй. Тэгээд Хууль зүйн яам маань энэ дээр бас ямархуу бодлого барьж байгаа вэ. Ялангуяа захиргаа, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд 5 жил бид нар яаж өөрчилж чадна гэж бодож байгаа талаар асуулт асууж, хариулт авмаар байна.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

С.Бямбацогт: Тэгэхээр энэ 5 жилийн үндсэн чиглэлийг 2026-2030 оны энэ хэрэгжихгүй бас хоосон цаас болчих вий гэж манай гишүүд их санаа зовоод байх шиг байна. Санаа зовж байгааг ойлгож байна. Санаа зовж байгаа бол харин яаж

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

сайжруулах вэ, яаж илүү хэрэгжүүлэх бодитой болгох вэ гэдэг дээр илүү анхаараасай. Энэ тал дээр бас зарчмын зөрүүтэй саналууд, тодорхой шийдлүүд гаргаасай гэж хүсэж байгаа. Би түрүүн хэлсэн шүү дээ. 30 жил бодлогогүй, төлөвлөгөөгүй явсан. Үүний үр дүнд Засгийн газар жил болгон 1 жил 6 сарын настай байсан. Төр бодлогогүй, төрийн бодлого тодорхой биш ийм л явж ирсэн. Өнөөдөр бас тодорхой бодлоготой болсон. Урт хугацааны бодлого, дунд хугацааны бодлого, богино хугацааны бодлого гээд энэ бодлогууд нь харилцан уялдаатай байх, салбаруудын бодлого нь хоорондоо уялдах, бүс нутагтайгаа бодлогоо уялдуулах, ганцхан Улаанбаатар гээд ганцхан таталцлын төвийг задлах, бүс бүрдээ таталцлын төвтэй болох гэх мэтийн юмнууд бол энэ үндсэн чиглэл дээр сууцхсан байгаа. Алсын хараа 2050-д суусан, үүнээсээ салбарлаад ингээд 5 жилийн хөтөлбөр дээр энийгээ л бид нар яаж бодитой, өшөө илүү хэрэгжүүлэх вэ, яаж хэмжих вэ, яаж хянах вэ, яаж үр дүнг нь тооцох вэ гэдэг дээр анхаарах ёстой. Хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй гэж үг байдаг. Өнөөдөр түвшнээ тодорхойлоод, 2030 он хүртэл ийм түвшинд хүрнэ л гэж байгаа.

Энэ дээр дахиад хэлэхэд энэ тийм 1950-иад онд хэлсэн үг. Номинчимэг гишүүн жж, Лука гишүүн хэлсэн үг биш. Та бол тэгж боддог юм шиг байна лээ. 1950-иад онд тийм Америкийн менежментийн эрдэмтдийн хэлсэн үг. Хаа хүрэхээ тодорхойлж чадахгүй бол хэзээ ч тэр цэгтээ хүрэхгүй гэж бас үг байдаг юм. Та бас олоод сонсчхоорой. Түүнтэй адилхан бид нар эхлэхдээ төгсгөлөө харах ёстой юм. Хаана байгаа тийм үү, одоо эхлэх гэж байна. Хаана хүрэх ёстой гэдгээ. Энэ хүрээндээ төрийн өмчит компаниудын бүтээмж, менежмент, үйл ажиллагааг сайжруулах, ил тод болгох энэ чиглэлд тодорхой ажлууд бас хийхээр төлөвлөсөн байгаа. Энэ дээр хөрөнгийн өгөөж, төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөж 9 хувьтай байгаа бол хөрөнгийн өгөөжийг 14 хувьд хүргэнэ гээд орчихсон байж байгаа.

Орон нутгийн өмчит 350 компанийн хөрөнгийн өгөөж тооцдоггүй бол орон нутгийн өгөөжийг тооцдог болно гээд тусчихсан байж байгаа. Энэ дээр Их Хурлын гишүүдээсээ хүсэхэд 1 асуудал бол төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийг Улсын Их Хуралд Засгийн газар өргөн бариад үндсэндээ 1 жил гаруй хугацаа өнгөрч байна. Энийг яаралтай хэлэлцээд батлаад өгөөч ээ. Тэгэх юм бол энэ дээр бодлого тодорхой болно.

Хоёрдугаарт нь, Нийтийн өмчийн тухай хуулийг бас Их Хуралд өнгөрсөн хавар өргөн барьсан. Яаралтай хэлэлцүүлээд бас батлаад өгөөч ээ. Тэгэх юм бол энэ төрийн өмчит компаниуд дээр байж байгаа хулгай зэлгий, янз янзын хардлага сэрдлэг харьцангуй гайгүй болно. Энэ бол асуудал шийдэгдэнэ. Гайгүй болно биш шийдэгдэнэ. Харин ер нь бол шийдээд явж байгаа. Ил тод болгох гээд. Цаашдаа энэ улам шийдэгдээд явах бололцоотой болно. Энийг та бүхэн бас энэ хуулиудыг хурдан батлуулаад өгөөч ээ. Тэгэх юм бол энэ бодлого маань .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Үнэхээр Иргэний болон Захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал олон жилийн турш тулгамдсан асуудал байгаа. Энэ оны 5 сард Алтангэрэл сайд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн бариад, хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн байгаа. Энэ асуудлаар бас яаралтай Хууль зүйн байнгын

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хорооноос Их Хурлын хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулж, Их Хурлаар батлуулах ийм томоохон өөрчлөлт хийхийн төлөө байгаа. Яг хуулийн ерөнхий суурь концепцыг бол Хууль зүйн сайд бол дэмжиж байгаа. Тэгээд би Алтангэрэл сайдыг бас Их Хурал дээр энэ манлайллыг үзүүлээд яваасай гэсэн бас ийм хүсэлтэй байгаа. Мэдээж тогтолцооны хувьд бас эргэж ярилцах, зарим .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

О.Номинчимэг: Бямбацогт сайд гараад явчихсан байх юм. Дуудаач би дахиад тодруулаад асуух гээд байна. Байна. Та тэгвэл тэндээ суучих. Лекц уншаад байх хэрэггүй. Зүгээр асуусан асуултад товч, тодорхой хариулчих хэрэгтэй. Тэгээд таны энэ оруулж ирж байгаа сая тайлбарлаад байгаа тэр үр өгөөжийг нэмэгдүүлнэ, ...-г сайжруулна гэдэг чинь 2030 онд одоо байгаа 9 хувиа 14 хувь болгоно гээд ороод ирсэн байхгүй юу. Тэгтэл бид нар хаврын чуулганаар баталсан 2026 онд Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд 2026 онд энийг чинь 15 хувь болгоно, байх ёстой гэдэг юм байхгүй юу. Тэгэхээр энэ бичиг баримтууд чинь өөрөө зөрөөд байгаа юм. Тэгээд тийм болохоор л асуугаад байгаа шүү дээ. Тэгэхээр юм асуухаар урдаас баахан урьтал лекц тавихаа бас больчих хэрэгтэй байна. Тэгээд хууль бол ороод ирчихсэн байгаа. Хууль бол явах ёстой гэдэг хатуу байр суурьтай байгаа. Энийг ч гэсэн чуулган дээр илэрхийлсэн. Төрийн өмчийн компанид орон нутгийн өмчийн компани дээр ер нь олон нийтэд ил тод байлгах IPO буюу олон .../минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 номерын микрофон өгье.

С.Бямбацогт: Яах вэ, Их Хуралд Засгийн газраас өргөн барьж байгаа бодлогын бичиг баримтууд, хууль, тогтоолын төслүүд маань бас Их Хурал дээр хэлэлцүүлгийн шатад бас өөрчлөгдчихөөд байгаа юм. Тэгээд энэ хоорондоо бас уялдахгүй байх ийм асуудал бас үүсэж байгаа. Тийм болохоор хууль, тогтоомжийн хоорондын уялдаа холбоог хангах, нийцлийг хангах, хоорондоо хийдэлгүй, зөрчилгүй, давхардалгүй байх тал дээр манай Их Хурал маань анхаарч ажиллах ёстой. Их Хурал маань. Бид Засгийн газар хуулийн төсөл, тогтоолын төслийг өргөн барьж байгаа. Энийг хийдэлгүй, давхардалгүй, хоорондоо зөрүүтэй биш батлах тал дээр Их Хурал анхаарч ажиллах ёстой. Энийгээ та бүхэн маань бас анхаарч хийж өгөөч гэдгийг хүсье. Номинчимэг гишүүн бас хуульч гишүүн. Та бас энд илүү анхаарч чадах байх. Найдаж байна.

Нийтийн өмчийн тухай хууль, дээрээс нь Орон нутгийн болон төрийн өмчит компанийн тухай хуулийг бас хурдан батлаад өгөөч ээ. Энийг та бүхнээс бас хүсье.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Үгүй ээ, тэр шалгуур үзүүлэлт бол Улсын Их Хурал оруулаад баталчхаагүй, Засгийн газар л оруулж ирсэн юм байна лээ шүү дээ. Та нар тэгээд битгий юм ярихаар жижүүрийн үг яриад л ингээд бай л даа. Бас деталь энэ тэр мэдэхгүй гэж бодоод байдаг юм уу. Бямбацогт сайд тэрийгээ одоо больчих. Тэгэх үү.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр би Энхбаяр сайдыг ерөнхийдөө концепцын хувьд тэр оруулж ирсэн хуулийг дэмжиж байгаа юм байна гэж ойлголоо. Энэ хууль хэлэлцэх эсэх ерөөсөө хийгдээгүй байгаа. Өргөн барьснаасаа хойш. Энэ дээр бас асуудал байна гээд өмнө нь Хууль зүйн яам түр байж бай гэсэн юутайгаар Байнгын хороогоор орж чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол Энхбаяр сайдыг энийг ер нь хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурал одоо хэлэлцээд явахад асуудалгүй гэсэн Хууль зүйн сайдын байр суурийг илэрхийллээ гэж ойлгож байна. Зөв үү. Энэ дээр тодруулга авчихъя.

Д.Цогтбаатар: Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Сая микрофон тасарчихлаа. Энэ концепцын хувьд мэдээж ярилцах асуудлууд байгаа. Өөрөөр хэлбэл иргэний болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэлийг Засгийн газрын түвшинд байлгах уу, Шүүхийн ерөнхий зөвлөлийн түвшинд байлгах уу. Одоо хуучин бүр Улсын дээд шүүхийн харьяанд гээд бүр ийм захиргааны чиг үүрэг өгөх ёстой юу, үгүй юу гэдэг энэ концепцын асуудал байгаа. Энэ дээр байр суурийн ойлголтын нэгдчихсэн байдал бол байхгүй байгаа. Процессын хувьд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулахтай холбоотой хөшүүрэг зохицуулалтуудыг сайжруулж байгаа олон асуудлууд байгаа. Тэрийг би зарчмын хувьд дэмжиж байгаа гэдэг ийм зүйл байгаа.

Тийм учраас энэ дэмжиж байгаа, дэмжихгүй байгаа гэдэг асуудлуудыг хуулийн төслийн гэдэс дотор, зарчим дээр нь ялгаатай бас авч үзэхгүй бол болохгүй.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

С.Бямбацогт: Тэгэхээр Номинчимэг гишүүн ээ, та бас өөрөө асуудлаа дутуу ойлгочхоод бас гишүүд рүү, сайд нар луу бас битгий ингэ. 2026 оны жилийн төлөвлөгөө дээр төрийн өмчит компаниудын зардлыг 15 хувиар бууруулна. Өгөөжийг биш, бүтээмжийг 30 хувиар нэмэгдүүлнэ гээд заачихсан. 2026-2030 оны таван жилийн үндсэн чиглэл дээр болохоор төрийн өмчит компанийн үр өгөөжийг 9 хувиас 14 хувь гэж нэмэгдүүлнэ гэж тооцсон юм. Харин тийм 30, 15, 14 чинь гурвуулаа 3 өөр тоо. Та уншаад судал. Өөрөө ойлгохгүй байж тэгээд бусад руу битгий ингэж дайр. Өгөөж, хөрөнгийн өгөөж нэг өөр тоо. Зардлыг бууруулах 15, Хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх 14, бүтээмжийг нэмэгдүүлэх 30 хувь. Энэ 3 тоогоо та ойлгодог болчихоод энд ярь за юу.

Д.Цогтбаатар: Манайхан юмыг ойлгоорой. Энд юу яасан шүү. Сая энэ Байнгын хороо чинь өчигдөр хуралдах байж байгаад, тэгээд бүх Байнгын хороод 1 хоног хойшилчихлоор өөр Байнгын хороотой давхцаж хуралдаад явчхаж байна шүү дээ. Тэгээд сайд нар нь орж ирж амжихгүй, нөгөө Байнгын хороонд асуултад хариулаад суугаад байгаа юм. Тэгэхээр бас яг та нарын асууж байгаа юунд Бямбацогт сайд орж ирээд, бүгдийг нь төлөөлөөд бас хариулаад байгаа. Түүнээс өөр хариуцсан сайд нар нь бас орж ирээд, та нарын асуултад шууд хариулах тийм боломж нөхцөл яг өнөөдөр хурал давхцаж байгаа болохоор бүрдэхгүй байна шүү дээ. Тэгэхээр бас гишүүд маань энийг ойлгож,, тал талдаа л ажлаа хуваарилаад л хийж байгаа. Тэгээд харилцан ойлголцож энэ юман дээрээ хандаарай л гэж хэлмээр байна. Баасанжаргал гишүүнд микрофон өгье.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Х.Баасанжаргал: Би Номинчимэг гишүүний асуулт дээр нэмээд асуучихъя. Яах вэ гол нь нөгөө бид нар юмаа уншаад л байгаа юм л даа. Тэгээд энэ хоорондын уялдаа гээд олон зүйлийг харах хэрэгтэй байгаад байна. Хэд хэдэн асуулт байна. Тэгэнгээ бас байр сууриа давхар илэрхийлээд, хариулаад явчхаарай гэж хүсье.

Өмнөх таван жилийн үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн үр дүнтэй бид нар танилцсан. Үнэхээр хангалтгүй байсан. Тэндээс авсан сургамж яг энэ шинээр орж ирж байгаа дээр юу байгаа вэ. Юу өөрчлөгдөж байгаа вэ. Бодлогын ямар чиглэл өөрчлөгдөж байгаа вэ. Тэрнээс үр дүнтэй болоод хэмждэг болсон гэдэг тухай асуугаагүй шүү. Тэгэхээр ямар сургамж аваад, ямар бодлогын ахиц гаргаж байгаа вэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

Хоёрдугаарт, жишээ нь ийм байгаа байхгүй юу. Дундаж давхаргыг нэмэгдүүлнэ. Ядуурлыг хэдэн хувиар бууруулна гэлээ. Тоо байгаа шүү дээ. Тэгсэн хэр нь яг ингээд тооцооллуудыг харахаар дундаж давхаргын эзлэх хувь 5 жилийн дараа 20 хувиар нэмэгдэнэ гэж байгаа юм. Тэгээд яг доор нь 50 хувиас доогуур, орлогын 50 хувиас доогуур амьжиргаатай хүн амын нийт эзлэх хувь нь 15,8-12 хувь болно гэж байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл орлого багатай иргэдийн тоо нь 3 хувиар буурсан хэр нь дундаж орлоготой иргэний хувь нь 20 хувиар нэмэгдчихээд, энэ хоорондох гар чинь ингээд гайхаад байгаа байхгүй юу. Эсвэл нөгөө гайгүй баян чинээлгүүд нь дундаж давхарга руу орох гээд байгаа юм уу. Яг яах гээд байгаа юм. Энд гар-ууд маш их гараад байна. Тийм учраас бид нар энийг тодруулаад байгаа юм. Энэ гайп дээр хариулт өгөөч ээ гэсэн үг. Энэ 40 дүгээр хуудсанд байна.

Дараа нь таван жилийн энэ үндсэн чиглэл, хойно нь 4 дүгээр хавсралт дээр хөрөнгө оруулалт гэж батлаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалт таван жилийн үндсэн чиглэл 2 хоорондоо яаж уялдаж байгаа вэ. Яаж үр дүн рүүгээ чиглэж байгаа вэ. Тэр дүн шинжилгээг нь хармаар байна. Хойно нь бол баахан хөрөнгө оруулалтуудын жагсаалтууд гаргачихсан байгаа. Тэрийг нь мэдэж байгаа. Тэгэхээр энэ үр дүнтэйгээ яаж уялдаж байгаа вэ гэдгийг хармаар байна.

Гуравдугаарт, иргэний орон зайг хамгаалах, тэлэхтэй холбоотой хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулахтай холбоотой 1 ч үг үсэг, 1 ч үр дүн байхгүй байна. Эсвэл хангалттай гэж үзэж байгаа юм уу. Ямар учиртай вэ гэдэг ийм асуулт байна.

Хамгийн сүүлд иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, иргэдийн оролцоо, ялангуяа орон нутгийн иргэдийн төлөөлөх чадавхыг сайжруулах иргэдийн Нийтийн Хурлын асуудал иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээр гарах үр дүн гээд ингээд яг нөгөө хүний эрхийн линзээр харах юм бол хэд хэдэн асуудлууд орхигдчихсон асуудлууд байгаад байна. Тэгээд нөгөө ажлын хэсэг дээрээ би өөрөө ажлын хэсэгт байгаа учраас зарчмын зөрүүтэй саналуудаа гаргаад, оруулаад явна. Хүний эрхийн линзээр харах юм бол хэд хэдэн асуудлууд энэ дээр байгаа шүү. Ялангуяа жишээ нь бэлгийн боловсролыг сайжруулна гэснээ үр дүн нь үр хөндөлтийг бууруулна гэххэж байгаа юм. Үр хөндөлтийн тоо буурна гэдэг чинь бэлгийн боловсрол сайжрах шууд үр дүн мөн байж таарах уу. Энэ дээр бас маш сайн бодож гаргах ёстой байх гэж бодож байна. Ингээд асуултдаа .../минут дуусав/

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Д.Цогтбаатар: Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүн байна уу. 5 дугаар микрофон. Тэгээд дараа нь энэ хүний эрхийн асуудлаар Хүний эрхийн Комиссоос бас хариулж болно. 5 дугаар микрофон.

С.Бямбацогт: Энэ өмнөх үндсэн чиглэлээс бас юугаараа ялгаатай вэ гэж. Энэ дээр нөгөө 30 жил бас төлөвлөлтгүй яваад ирчихсэн. Тэгээд анхны таван жилийн төлөвлөлт буюу үндсэн чиглэл 2021 онд Улсын Их Хурлаар баталсан. 2025 он дуустал энэ төлөвлөгөө дээр бас бид нар анхных байсан учраас алдсан. Зөв тооцож төлөвлөж оруулж чадаагүй зүйлүүд нэлээн байсан юм байна лээ. Үүнийгээ бас Засгийн газар дүгнээд, энэ өмнөх таван жилийн төлөвлөлт маань хэдэн хувийн биелэлттэй байна вэ гэж гаргаж үзсэн. Ингээд үзэхэд үндсэндээ 54 хувийн биелэлттэй байсан. 2021 онд төлөвлөж байхдаа яг 2025 оны жилийн эцэст яг ийм л юмнуудыг хийж хэрэгжүүлж дуусна гэж тооцсон зорилтдоо хүрэхэд 54 хувьтай. Юунаасаа болоод юун дээрээ алдчихав яасан, ийсэн гэдгийг манай Эдийн засаг, хөгжлийн хөгжлийн яам бас нэлээн анхаарч ажилласан. Ингээд анхаарч ажиллаад, шинжлэх ухааны академийн Бага чуулган, Их чуулган гээд бас олон байгууллагууд, эрдэмтдийг оролцуулж хэлэлцүүлэг хийгээд, урьд нь бас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, мөн бас төлөвлөлт дээр ажиллаж байсан улс төрчид, эдийн засагч, судлаачдыг бас оролцуулаад ингээд үндсэндээ өмнөхөөсөө ялгаатай нь бол нөгөө гол шалгуурууд, үзүүлэлтүүд энийг нь маш тодорхой болгосон. Олон улсын стандарт, загварчлалын дагуу тооцдог, хэмжих нэгжүүдийг оруулж ирж, түүгээрээ одоо байгаа түвшнээ тодорхойлоод, 2026 онд ийм түвшинд байгаа юм байна. 30 онд ийм юманд хүрэх юм байна гэдгээ ингээд тодорхойлж илүү нарийвчилж өгснөөрөө өмнөхөөсөө илүү сайжирсан гэж манай Эдийн засаг, хөгжлийн яамныхан бас хэлж байгаа гэдгийг бас хэлье.

Хөрөнгө оруулалтын төслүүдийн тухайд бол 30-аас дээш тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл төсөвт өртөг бүхий төслүүдийг үндсэндээ 2026-2030 онд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө оруулалтуудаар хийж хэрэгжүүлж болох юм гэсэн үндсэндээ 14 мега төслөөс гадна бас Монгол Улсын эдийн засаг, нийгэмд ач холбогдолтой томоохон төслүүдийг хийж болох юм гэдгийг бас эрэмбэд оруулсан байгаа.. Үүнийгээ ирүү илүү нарийвчлаад, жил жилийн төлөвлөгөөнд суулгана. Жил жилийн Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд суулгана. Үүнээсээ улсын төсвөөс шаардлагатай бол төсөвтөө суулгаад явах ийм зарчмаар явдаг. Үүнийхээ дагуу бас явна гэдгийг бас хэлье. Тэгээд илүү нарийвчилсан үзүүлэлтүүдийг манай Эдийн засаг, хөгжлийн яам хариулна. Мөнгөнсүх хариулна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: 2 номерын микрофон.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга Мөнгөнсүх. Гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахдаа үр дүнд суурилсан аргачлалыг ашигласан. Ингээд 4 түвшний үр дүн шалгуур, үзүүлэлт нэг бүрийг гаргаж, энэ гарч байгаа үр дүн хоорондын уялдаа холбоо, бие биедээ нөлөөлөх эерэг, сөрөг нөлөөллийн ийм үзүүлэлтүүдийг гаргаж ажилласан байгаа. Тухайлбал, хамгийн өндөр нөлөөтэй, бусдадаа хамгийн их нөлөө үзүүлж байгаа бодлогын хүрээ гэхэд байгаль орчны бодлогын хүрээ гэхэд 180 орчим үр дүнд болон шууд болон дам нөлөөллийг үзүүлж ажиллаж байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Мөн бид бүхэн боловсруулахдаа өмнөх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн ололт амжилт, алдаа дутагдал дээр тулгуурлаж ажилласан байгаа. Ингээд 330 үр дүнг 426 шалгуур үзүүлэлтээр нэг бүрчлэн хэмжиж, үнэлж дүгнэхээр аргачлалын дагуу боловсруулсан. 4 дүгээр хавсралт буюу улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь энэ 8 бодлогын хүрээний 330 үр дүнд шууд идэвхтэй нөлөө үзүүлэх 47 төсөл, 27 үр дүнд шууд нөлөө үзүүлэх ийм төслүүдийг эрэмбэлж оруулсан байж байгаа. Яг энэхүү үр дүнг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүд нь бол жилийн хөгжлийн төлөвлөгөө дээрээ суугаад явах ёстой байгаа.

Гишүүний асуусан саяын 2 дундаж давхаргатай холбоотой, орлоготой холбоотой үр дүнгүүдийг бол өөр өөрийн тусгайлсан аргачлалаар хэмжиж гаргаж ирж, бодитой хүрэх үр дүнг бол тооцоолсон байгаа..../минут дуусав/

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон гүйцээгээд хариулъя.

Б.Мөнгөнсүх: Энэ ташрамд нийт төсөл дээр тооцоолох шаардлагатай буюу 40 орчим үзүүлэлтүүдийг тусгаж оруулсан байгаа. Энэ нь бол цаашлаад бидний хэрэглээнд нэвтрүүлэх ёстой статистикийн чадавхаа улам бүр сайжруулах, улам бүр бодитой үр дүнтэй тооцоолдог, төлөвлөдөг энэ арга чадварыг улам бүр сайжруулахад ач холбогдол үзүүлэхээр байгаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүн ээ, Хүний эрхийн Комиссоос асуух уу. Саналаа бол өгсөн л байгаа л даа. Түрүүн та хүний эрхийн асуудлаар яриад байхаар комисс хариулах уу. Энхболд. Комисс бол саналаа өгч оролцсон байгаа байх. 1 дүгээр микрофон дээр очоод суучих. 1 дүгээр микрофон өгье.

Б.Энхболд: Та бүхнийхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр энэ хөгжлийн үндсэн чиглэлийг батлахад Хүний эрхийн Үндэсний Комиссоос тодорхой боловсруулсан төлөвлөгөө дээр санал авсан. Энэ санал дээр бид нар яг ойрын 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж болох нийт 16 саналыг хүргүүлсэн. Эндээс үндсэндээ 4 чиглэл нь тусаж орсон байна лээ. Тэгэхээр манай хүргүүлсэн санал бол бид бүхэн нөгөө Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөрөөсөө арай өөр чиглэлд байх байх гээд илүү нөгөө ойрын хугацааны саналуудаа өгчихсөн. Тэндээс тодорхой 4 хэсэг нь орсон байна лээ. Яг нэг бүрчлэн боловсруулах, хэлэлцүүлэх энэ асуудал дээр манайхаас тэр иргэний орон зай, хэвлэл мэдээлэлтэй холбоотой асуудлууд дээр санал өгөөгүй байгаа. Одоо энэ дээр зарчмын зөрүүтэй саналууд гаргавал ажлын хэсгийн ахлагчид уламжлаад оруулах ийм боломж нөхцөл байгаа юм байна.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Яах вэ, нөгөө хүний эрхийн линзээр яг энэ ойрын одоо энэ чинь ойрын 5 жилийн бид нарын ажлын гол үндсэн төлөвлөгөө, чиглэл гарч байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ чинь маш хариуцлагатай баримт бичиг байхгүй юу. Төсөв маань өөрөө энд захирагдана. Тэгж би ойлгож байгаа. Төсөв өөрөө энэ 5 жил дээрээ захирагдах ёстой. Тэгээд ингээд харахаар бид нар ямар ахиц дэвшил гаргах гээд байгаа юм бэ. Ялангуяа хүний амьдрал дээр гаргах, ялангуяа хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах дээр ямар ахиц дэвшил гарах юм бэ гэдэг үүднээс нь бид нар дандаа хараад, би бол хувьдаа хараад байгаа гэсэн үг. Жишээ нь энэ 45 дугаар хуудсанд нийгмийн халамжийн нийт зардалд зорилтот бүлэгт чиглэсэн зардлын эзлэх хувь гэснээ 26,4-36,8 хувь болж өсөх нь гэж харагдаад байгаа

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байхгүй юу. Тэгэхээр зардлаа өсгөх гээд байна гэж харагдаад. Гэтэл энэ нь илүү нөгөө оновчтой болох гэдэг зорилго уг нь яваад байгаа юм болов уу гэж би зүгээр цаана нь тийм санаа байгаа юм болов уу гэж ойлгоод. Гэтэл зардал өсөх тухай энэ дээр чинь гараад байх юм гэх мэтээр энэ дотор маш олон ийм гар-ууд гараад байна.

Д.Цогтбаатар: Тодруулъя. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Тэгээд энэ ойрын 5 жил хийх энэ Засгийн газрын үндсэн чиглэл дотор Хүний эрхийн Үндэсний Комисс бол манай Их Хурлаас байгуулагддаг. Гэтэл хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих буюу хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн хүрээнд гарсан Улсын Их Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг Хүний эрхийн Үндэсний Комисс хариуцахаар орж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нь өөрөө болох юм уу. Нөгөө тогтолцоондоо зөв юм уу гэдгийг хармаар байх юм. Энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс ямар байр суурьтай байгаа юм. Энэ 46 дугаар хуудсан дээр бас тийм зүйл орж ирсэн.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

С.Бямбацогт: Баасанжаргал гишүүн маш чухал асуудал хөндөж байна. Ерөөсөө яг энэ 5 жилийн үндсэн чиглэл дээр тулгуурлаж, 2028 оны улс төрийн сонгуульд оролцох намуудын мөрийн хөтөлбөрийг яг энэ дээр л тулгуурлана. Энэ үндсэн бодлогын бичиг баримт. Үүнээс зөрөх юм бол Сонгуулийн ерөнхий хороо бүртгэхгүй. Ингээд яг ийм байдлаар цаашдаа төлөвлөгөө яг энэ дээр л тулгуурлана. Яг төлөвлөгөө дээрээ тулгуурлаж, төлөвлөгөөг биелүүлэхийн тулд төсөв батлагдана. Төсөвлөлт хийгдэнэ. Ийм л зарчмаар явна л даа. Яг таны хэлж байгаа үнэн. Тэр зардалтай холбоотой асуудал дээр түрүүн зарим гишүүн бас зардал, бүтээмж, орлого, үр өгөөж эд нарыг бас хоорондоо хольж хутгаад, ялгахгүй, мэдэхгүй байх шиг байна лээ. Тэгэхээр энэ дээр тиймэрхүү бас асуудлуудыг бас ялгаа зааг нь нэлээн сайн тодорхой гаргаж өгье. Цаашдаа алдаатай заалтууд байх юм бол тэрийг нь бас нэмээд, суулгаад тусгаад өгье. Бас одоо анхны хэлэлцүүлэг учраас бид нар засах бололцоонууд байгаа. Анхны хэлэлцүүлэг дээр бид нар юуг ч, яаж ч өөрчилж болно. Энэ бол Улсын Их Хурлын бүрэн эрх.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон өгье. Хүний эрхийн Комисс

Б.Энхболд: Тэгэхээр одоогийн боловсруулчихсан байгаа төсөл дээр нийтдээ Хүний эрхийн Үндэсний Комисстой холбоотой 4 заалт. 1 дээр нь Боловсролын яамыг хамтарсан хариуцагч гээд, үндсэн 3-ыг нь өөрөө хариуцна гээд биччихсэн байгаа нь бол Баасанжаргал гишүүний хэлээд байгаа саналтай комисс санал нэг байгаа юм. Өөрөөр хэлбэл бид нар үндсэндээ өөрөө хэрэгжүүлээд, өөртөө хяналт тавиад, тэгээд энэ сүүлдээ юу болдог вэ гэхээр мэдээж төсөв хөрөнгө хэрэгжилт шаардаад ирэхээр буцаад комиссын асуудал болж хувираад байдаг. Тэгэхээр энийг холбогдох Засгийн газрын яамдтай хамтран хэрэгжүүлэх, мөн үндсэн хариуцагчийг нь Засгийн газрын яамд руу оруулах ёстой гэж ингэж бодож байгаа. Түрүүн тэр бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хүний эрхийн асуудлууд дээр бол Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас маш тодорхой хариулт өгөх хэрэгтэй байх гэж ингэж харж байгаа. Яагаад энэ төлөвлөгөөндөө тэр хүний эрхийн онцгой анхаарал татаж байгаа асуудлуудыг

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тусгаж оруулж ирэхгүй байгаад байгаа вэ гэдэг дээр ямар эрэмбэ шалгуур байсан бэ гэдгийг бас/минут дуусав/

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Уг нь гэдэс дотор нь бас ороод асуух асуултууд байгаа ч гэсэн өмнө нь бас хэлэх ажлууд байна. Хууль зүйн сайд бичиг баримтаа боловсруулахад оролцсон юм уу. Улсын Их Хурлын чуулган дээр энэ бичиг баримттай холбоотой асуудал дээр би бичиг баримт дээр нь биччихсэн учраас Ерөнхий сайдаас нь асуусан юм. Тэгээд бичиг баримт боловсруулсан хүмүүс нь Ерөнхий сайдаа бас хэлэх ёстой байх. Үндсэн хуулийн цэцтэй холбоотой, иргэний үндсэн эрхтэй холбоотой асуудлыг та нар шийдэх гэж байгаа юм уу. Энэ нь өөрөө Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө учраас Засгийн газраас манайд хамаагүй гэж хэлэхгүй. Энэ чинь Монгол Улсын л хувь заяа. Тэр агуулгаар асуусан чинь бид бол эрх мэдлээ давж алхаж чадахгүй гэдэг утгатай юм хэлж байна лээ. Гэхдээ энэ дотор нь Үндсэн хуулийн цэцтэй холбогдуулаад Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулаад 2, 3 том юм биччихсэн байгаа байхгүй юу.

Тэгээд би одоо асуух гэж байна. Сая үгэн дотор бас гарч ирлээ. Бид ер нь зарчмаа зөв болгохгүй бол сонгуулийн үеэр энэ бичиг баримттай нийцээгүй намыг бол сонгуульд оролцуулахгүй гэж хэлэх бол Үндсэн хуулийн бус шүү дээ. Ардчилсан улс оронд Үндсэн хуультай нийцэж л байвал филарализм буюу олон ургалч үзлийг олон намын тогтолцоог бид дэмжиж, тэд хөгжлийг өөрөөр харах эрхтэй байхгүй юу. Гэтэл 1 Улсын Их Хурал, 1 эрх баригч өөрийнхөө өгсөн баримт бичгийг гаргачхаад сонгууль энэ хүрээнд явна гэж галзуурах бол ер нь галзуурал шүү дээ. Бүр 2050 гэж бичиж байгаад, тэгээд улс төрийн намууд энэ бичиг баримттай нийцээгүй учраас ингээд маргаан үүсгээд байж байна. Бид энийгээ жоохон хэтрүүлж үнэлж ерөөсөө болохгүй. Одоо би энэ дотроос хэд хэдэн ийм асуулт асуух гээд байгаа юм.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг бид баталчихсан. Улсын Их Хурлын баталсан хүчин төгөлдөр баримт бичиг байгаа. Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авна гээд 1 заалт байж байна. Энэ 7.2.1.9 дээр. Энэ гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоогоо сэргээх гэж байгаа юм уу. Эсвэл энэ дээрээ биччихсэнээрээ олон улсын стандартыг нийцүүлнэ гэж хэлж байгаа нь яг юуг хэлж байгаа юм.

Хоёрт нь дахиад шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг шийднэ гээд шийдвэр гүйцэтгэлийн хэсэг дээр биччихэж. Дэлхий нийтээрээ зарчмыг барьж байгаа. Тэр дундаа Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудал дээр ч гэсэн шүүгч гаргасан шийдвэрээ хэрхэн, яаж биелүүлэх вэ, ямар арга замаар энийг хангах вэ гэдгийг шийдвэртээ бичиж байгаа юм. Энийгээ шийдэхийн тулд урьдчилаад шийдвэрээ бодитой болгохын тулд ямар хөрөнгийг битүүмжлэх вэ, хөрөнгийн эргэлтэд яаж хяналт тавих вэ гэдгээ бас шийдэж байгаа юм. Энийг нь шийдэхийн тулд/минут дуусав/

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Х.Тэмүүжин: Тахартай адилхан шүүн таслах үйл ажиллагааг хэвийн явуулахад нь туслалцаа үзүүлэх байгууллагуудыг байгуулж байгаа юм. Тэрнийхээ үр дүнд л шүүх шийдвэрээ зөв гаргаж байгаа, шийдвэр нь биелж байгаа. Монгол

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Улсад яадаг вэ гэхээр шүүхийн шийдвэр гарсны дараа шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой шүүхийн маргаан яваад эхэлдэг. Тэгээд 3 шатаар хэрэлдээд суучихдаг. Шийдвэр хэзээ ч хэрэгждэггүй. Нөгөө улс орнууд чинь шүүхийн шийдвэр гарсны дараа шийдвэр гүйцэтгэлийн маргаан явахгүй шүү дээ. Шийдвэрт нь маш тодорхой арга замуудыг нь заагаад өгчихсөн байдаг учраас зүгээр л Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тэрийг нь хэрэгжүүлдэг гэх мэтчилэн энэ туршлагаар асуудлыг шийдэх гэж байгаа юм уу. Эсвэл дахиад энэ дээр чинь ямар ч хэмжигдэх, хийх арга замгүйгээр бичигдсэн ерөнхий ийм өгүүлбэрүүд байгаад байна.

Дахиад хууль зүйн туслалцаатай холбоотой хэсэг дээр өмгөөлөгчдийн боловсролыг нэмэгдүүлэх гэж байгаа юм уу, эсвэл өмгөөлөгчдийн хууль зүйн туслалцаа үзүүлэх механизмуудыг сайжруулах гэж байгаа юм уу. Дахиад хэмжигдэхгүй.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд авах уу. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Тэгэхээр хууль зүйн туслалцаатай холбоотой асуудал дээр чинь хамгийн их зовлон гаргаж байгаа нь юу вэ гэхээр өмгөөлөгч прокурортой, шүүхтэй уулзаад маргах биш, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гээд хуучин нөгөө мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хэрэлдээд суугаад байгаа шүү дээ. Дэлхий нийтээрээ 1 л зарчим барьж байгаа. Хууль сахиулагчтай хэрэлддэг хуульч гэж байхгүй шүү дээ. Хууль зүйн туслалцааг хаана авч байгаа вэ гэхээр ерөөсөө шүүхийн процесс дээр. Тэгэхээр энийгээ сайжруулах гэж байгаа юм уу. Энийг сайжруулъя гэвэл өмгөөлөгч прокурор дотор гомдол гаргаад, дээд шатынх нь прокурор луу гомдол гаргадаг биш, шүүхийн процессын маргаанаа шүүх дээр шийддэг тийм тогтолцоо руу явж байгаа шүү дээ. Дэлхий нийтээрээ тийм байгаа.

Тэгэхээр энийг ингэж шийдэх гэж байгаа юм уу, эсвэл яаж шийдэх гэж байгаа юм гэх мэтчилэн ингээд ямар ажил хийх гэж байгаа юм. Үр дүн нь юу өөрчлөгдөх гэж байгаа юм гэдэг бодит хэмжигдэхүйц ямар ч үг үсэг алга. Энэ дотор уншихаар би энд ганцхан л зүйлийг уншаад өгье. Их сонирхолтой. Дуусгачих .../минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

С.Бямбацогт: Сая бас Тэмүүжин гишүүн бидний нөгөө танин мэдэхүй, бусад хүмүүст бас ойлгогдох асуудал асууж байна. Анхаарах ёстой. 2028 оны сонгуулиар энийг барихгүй бол бүртгэхгүй гэж. Яагаад ингэж хязгаарлаж, хааж боож, хязгаарлаж байгаа юм бэ гэж. Ингэж хязгаарлаж байхгүй бол бас болдоггүй. Энэ бас Монголчууд өнгөрсөн хугацаанд бас гарсан гашуун түүх, туршлага. Анх улс төрийн намууд 2004 оны сонгуульд оролцохдоо л бүгдээрээ хүүхдэд 10 мянга өгнө гээд л эхэлсэн. Дараа нь тэгээд улсын эдийн засаг, төсвөөс дааж давахгүй ачаалалтай амлалтуудыг авдаг болж эхэлсэн. Тэгээд 2008 оны сонгуулиар 2 нам нь иргэн болгондоо 1 сая төгрөг олгоно гэсэн. Нөгөөдөх нь уралдаад 1 сая 500 болгоно гэсэн. Ингээд үндсэндээ иргэдийг ерөөсөө бэлэнчлэх, ерөөсөө л амлуулах, улс орны эдийн засаг, төсөв даахгүй том амлалтуудыг авах.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Яах уу, гүйцээгээд хариулах уу. 5 дугаар микрофон.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

С.Бямбацогт: Үндсэн хариулт гэж ойлгож байгаа. 3 минут байх. 3 минутаар өгчхөөрэй. Тэгэхээр ингэж уралдаж явсаар байгаад улс орны эдийн засаг даадаггүй, төсөв даадаггүй, Монгол Улсын өр зээл барагдахаа больсон. Нөгөө хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, хувийн хэвшлийг дэмжих, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох энэ бодлогоо хэрэгжүүлж чадахаа больсон. Ингээд л ерөөсөө бэлэнчилдэг ийм л юм руу орчихсон. Одоо энэ оны төсөв дээр ч гэсэн Засгийн газар хөнжлийнхөө хэрээр хөлөө жийгээд ийм төсөв зардлаар хөрөнгө оруулалт хийе, ийм төсөв зардлыг цалин тэтгэвэр нэмэхээр шийдье гэж оруулж ирсэн. Үүнийг ингээд л манай Их Хурлын гишүүд 3 сая 500 болгоно гэж даахгүй юм нэмнэ гэж дайрсаар байгаад л Их Хурал дээр нэмээд явчихсан. Үүнийх нь үр дагаварт инфляц ирэх онд хий яаж өсөх вэ. Дараа нь эргээд бусад хувийн хэвшилдээ яаж сөргөөр нөлөөлөх вэ, ямар ч тооцоо байхгүй. Үүний үр дагавар гарна бас.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Дахиад гүйцээгээд. Таных түрүүнийх 3 минут байсан. Та гүйцээчих.

С.Бямбацогт: Үгүй үгүй, байгаагүй. Тийм болохоор иймэрхүү хөнжлийнхөө хэрээр хөлөө жийдэггүй, зүгээр л иргэдэд, сонгогчдод таалагдахын тулд хэт популист юм ярьдаг. Үүнийг л хязгаарлая. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийдэг болъё. Энэ хязгаар дотроо багтаагаад Монгол Улсын төрийн бодлого нь тодорхой байх, төрийн бодлого нь тогтвортой байх, харилцан уялдаатай байхын тулд л энэ Үндсэн хуульдаа заалт оруулаад Үндсэн хуулийнхаа заалтын дагуу Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай тухай хууль, мөн бас Сонгуулийн тухай хууль гээд энэ заалтууд дээр энэ бодлогын бичиг баримтууд, төрийн бодлого дотроо л хэдүүлээ зангидагдаж, захирагдаж явъя гэдэг үүднээс ингэж өгсөн. Энэ хязгаарлалтыг аваад хаячих юм бол эргээд нөгөө замбараагүй популист байдал маань улам газар авах, гаарах, улс орны эдийн засаг хүндрэх, ард иргэд маань бэлэнчилдэг болох, эргээд нөгөө том бодлого маань хэрэгжихгүй байх, том төслүүд, эдийн засаг маань тэлэх хувийн хэвшлээ дэмжих энэ орон зай маань хаагдах ийм эрсдэлтэй учраас л ингэж бас тодорхой хязгаарлалтууд хийж байгаа шүү. Энийг бас зөв ойлгох байх гэж бодож байна. Бусад асуудал дээр Хууль зүйн сайд хариулчихъя.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайд.

Б.Энхбаяр: Хууль, эрх зүйн салбарын чиглэлээр ирэх 5 жилийн төлөвлөгөөнд томъёологдсон асуудлыг тодорхой, ойлгомжтой болгох гэдэг зарчмын байр суурьтай санал 1 байна. Тэр дотор хөндөж ярьж байгаа Үндсэн хуулийн цэцийн тухай болон Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль үндсэн чиглэлд суусан учиг нь бол хэдийгээр Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурал дээр энэ ажлын хэсэг ажиллаж байгаа ч гэсэн Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам дээр энэ хуулийн төслийн холбогдох тандан судалгаа боловсруулалтын асуудал дээр нэлээн манлайлалтай ажилласан утгаараа бас ингэж орсон. Ер нь Цэц, цэцийн процессын хуулийг би Улсын Их Хурлын гишүүд санаачлаад өргөн бариад явах нь илүү зохимжтой байх гэж бодоод байгаа. Засгийн газар биш. Яагаад гэхээр Засгийн газар өөрөө бас гүйцэтгэх дээд байгууллага байдаг ийм учиртай. Энэ минут ч багтахгүй, дуусчих гээд байна..../минут дуусав/

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ц.Сандаг-Очир: Одоо Эрдэнэболд гишүүн асуултаа асууя. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгөөрэй.

С.Эрдэнэболд: Би тодорхой л юм асуух гээд байна л даа. Юу гэхээр энэ 2024 оны 7 сарын 9-нд Засгийн газар байгуулагдахдаа 578 зүйл заалттай мөрийн хөтөлбөрийг “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэдэг нэртэйгээр батлаад, түүнийгээ 11 хэмжих нэгжээр хэмжихээр тодорхойлсон юм. Одоо хүний хөгжлийн индекс, авлигын индекс гээд нийтдээ 11. Ингээд сая 6 сард Засгийн газар солигдлоо шүү дээ. Ерөнхий сайд солигдоод, тэгээд одоо яг манай гишүүдийн асуугаад байгаа зүйл нь жишээлбэл Учрал сайд юу гэж байна гэхээрээ төрийн өмчит байгууллагуудыг цөөлнө. Татаас аваад байдаг ашиггүй газруудыг цөөлнө энэ тэр гээд ийм тодорхой юмнууд хэлчихсэн. Тэгэнгүүт нөгөө 14 мега төсөл гээд явж байсан чинь сүүлийн үед Ерөнхий сайдын хэлээд байгаа байр суурь дээр бол 14 мега төслөөс зарим нь ач холбогдлоороо хойшоо эрэмбэлэгдэхээр харагдаад байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр бид нар нөгөө замын зургаа тодорхой харах, Засгийн бодлогыг тодорхой ойлгож байж Их Хурал чинь юуг нь яаж дэмжих юм, юун дээр нь бид нар өөр байр суурь, зарчмын зөрүүтэй санал гарах юм гэдгийг тодорхой болгох гээд байгаа юм. Тэгээд Их Хурлын гишүүд энэ өнцгөөсөө яг тодорхой зүйл асуугаад байнгуут сайд нар энийг субъектив хүлээж аваад байх шаардлагагүй гэж би хэлэх гээд байхгүй юу. Нэг.

Хоёрдугаарт, энэ ноднин 2024 оны 11 сард бид нар 28-нд энэ Их Хурал хүн төвтэй байх таван тулгуурт бодлого гээд гаргачихсан. Тэгэхээр өөрөөр хэлбэл Их Хурлаас гарч байгаа бодлого болгон энэ хүн төвт үзэлтэйгээ ингээд уялдаж байна гэдэг их сүртэй нэртэй юм гаргачихгүй юу. Тэгсэн чинь одоо яаж байна гэсэн чинь өнгөрсөн жилийн хөгжлийн хөтөлбөр, энэ жилийн гаргаж байгаа хөгжлийн хөтөлбөр 2-ын эрэмбэ нь өөрчлөгдчихсөн. Жишээлбэл, тэр боомтын асуудал ч гэдэг юм уу, Хөрөнгө оруулалтын асуудлуудын байр нь өөрчлөгдөөд, ноднин жилийн 4-д байсан асуудал таван жилийн төлөвлөгөө дээр 1 рүү ороод ирж байгаа юм. Хүний хөгжилтэй холбоотой асуудал.

Тэгэхээр одоо миний асуух гэж байгаа зүйл болохоороо яг энэ тодорхой өмнөх Засгийн газрын бодлого хэчнээн хувь нь одоо яг бодлого болоод урагшаа явж байгаа юм бэ гэдэг тодорхой зүйлийг асуух гээд байгаа юм. Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуух гээд байгаа юм.

Хоёрдугаарт, тэр Батжаргалын Төгөлдөр дарга аа. Энэ хөрөнгө оруулалттай холбоотой төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын асуудал яг одоо энэ Эдийн засаг, хөгжлийн яамны төлөвлөж байгаа хангалттай түвшинд явж байгаа юм уу. Яг яаж байгаа юм бэ. Энэ дээр тодорхой мэдээлэл өгөөч.

Энэ ном дээр ямар асуудал байна гэхээр нийтдээ энэ салбар бичиж байгаа юм. Бодлого хэрэгжүүлэх салбар. Жишээлбэл боловсрол ч гэдэг юм уу, ингээд цаашаагаа эрүүл мэнд ч гэдэг юм уу. Тэгэнгүүт энэ үр дүнг юу гэж бичиж байна гэхээрээ боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна гээд биччихэж байгаа юм. Эрүүл мэнд дээр жишээлбэл эмийн чанарыг сайжруулна гээд биччихэж байгаа юм. Гэтэл нөгөө хэмжих нэгжээ энэ дээр яаж оруулах юм бэ гэдгийг л асуугаад байгаа юм. Жишээлбэл, манай Төв аймаг, Дархан, Сэлэнгэ 72.334 хүүхэд 1-12 дугаар ангид сурч байгаа. Тэрнээс ойролцоогоор .../минут дуусав/

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Д.Цогтбаатар: Нэмэлт 1 минут өгье.

С.Эрдэнэболд: Тэгээд тэндээс 1 мянга гаруй хүүхдүүд жишээлбэл дотуур байрны асуудалтай буюу өвөл бол хүйтэн нөхцөлд сурч боловсорч байгаа байхгүй юу. Тэгэнгүүт жишээлбэл тэр нь Улсын Их Хурлын гишүүдээс санал болоод ирэнгүүт бид хөрөнгө оруулалтын санал тусгангуут тэр намын санал, энэ намын санал гээд популизмд өртчихөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар бол энэ санаануудаа Эдийн засаг, хөгжлийн яам руу явуулдаг.

Тэгэхээр жишээлбэл хэмжих нэгж бол боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна гэж байгаа бол үүнтэй холбоотой хатуу, зөөлөн дэд бүтцийг ямар нөхцөлд, яаж, ямар хэмжих нэгжээр сайжруулах юм бэ гэдгээ л энэ хавтгай дотроо оруулчихаач гээд байгаа байхгүй юу. Энд бол үндсэн хариуцагч, хамтрагч, хамтрагч, арга зам, үр дүн гэсэн ийм 4 ийм нүд байгаад байгаа юм. Хүснэгтийн нүд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ тодорхой болгочхоод, мөн бас хиймэл оюун ухаан, хиймэл оюун, AI энэ төрийн бүтээмжийг 70 хүртэлх хувиар сайжруулна гээд олон улсад сүүлийн үед судалгаа гараад байгаа. Хятад улс гэхэд л бүх сургуульд энэ чиглэлийн хичээл орчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ таван жилийн хөтөлбөртөө төрийн бүтээмжийг сайжруулахад AI-г яаж ашиглах талаар .../минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн маш чухал асуудал хөндлөө. Өмнө нь батлагдсан, одоо хэрэгжиж байгаа бодлогын бичиг баримтуудтай энэ ирээдүйд хэрэгжих 2026-2030 онд хэрэгжих бодлогын бичиг баримт маань яаж уялдаж байгаа вэ гэж. Тэгээд 2024 онд сонгуулийн дараа Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам хамтраад Засгийн газар байгуулсан. “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хэмээх нэртэй мөрийн хөтөлбөрөө баталсан. 2028 оны 6 сар хүртэл, 2028 он дуустал энэ хөтөлбөр хэрэгжиж дуусна. Энэ бодлогын бичиг баримттай энэ 2026-2030 он хүртэл хэрэгжүүлэх бодлогын бичиг баримт яв цав уялдаж байгаа. Яагаад гэвэл зөрчилдөх ёсгүй. Хуулиараа, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар уялдуулж нийцүүлж хийнэ гэхсэн.

Тийм болохоор 2026-2028 он хүртэл бодлого маань ингээд уялдаж байгаа. 2029, 2030 он энэ дээр нэмэгдэж байгаа. 2029 онд, 2030 онд. 2028 оны сонгуульд нэр дэвшүүлэх, мөрийн хөтөлбөр дэвшүүлэх намууд сонгуулийнхаа үр дүнгээр бас 2029, 2030 оны энэ таван жилийн үндсэн чиглэл дээр тусгагдсан асуудлуудыг бүгдийг нь тэр дээр нь нэмээд, өөрчлөх шаардлагатай өөрчилж байгаад 2032 он хүртэлх Засгийн газрын үндсэн чиглэлээ 2030-2035 оны мөрийн хөтөлбөрөө 2030-2035 оны үндсэн чиглэлээ ингээд уялдуулаад явах байдлаар өмнөхтэй болон одоо хэрэгжиж байгаатай, ирээдүйд хэрэгжихтэй хоорондоо уялдаатай байх асуудлыг бид нар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар хийгээд өгчихсөн. Яг ийм байдлаар хэрэгжиж байгаа. Хэрэгжинэ гээд хэлчихье.

Төслүүдийн тухайд 14 мега төсөл хэрэгжинэ. 14 мега төслөөс одоогийн байдлаар Эрдэнэбүрэний УЦС, Хил холболтын төмөр зам, Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл, Уран гэсэн том 4 төсөл хэрэгжээд явж байгаа. Эндээс ач холбогдлоороо гээд эрэмбэлэгдээд ямар нэгэн байдлаар хасагдсан зүйл байхгүй. Хүлээгдэж байгаа төслүүд жоохон удаашралтай явж байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Удаашралтай явж байгаа дээр ярих юм бол нөгөө сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр. Нар, салхины эрчим хүчний томоохон төслүүд хэрэгжилт жоохон удаашралтай байна. Мөн Хэрлэн-Тооно энэ урагшаагаа бас нөгөө Хэрлэн голыг урагш нь ус татах, Орхон-Онги гээд одоо бас төслүүд, Эгийн голын УЦС-ын төслүүд гээд энэ төслүүд бас 2 хөрштэй ойлголцох, бодлого нэгтгэх, зөвшилцөх шаардлагатай учраас үндсэндээ нэлээн бас удаашралтай байна.

Үндэсний хиймэл дагуул одоо бас манай их хурал дээр ирээд нөгөө Францын Засгийн газартай хамтарч хийнэ гэж байгаад гишүүд маань бас жоохон буруу бодлого байна гээд ингэчихсэн байгаа. Үүнээсээ болоод жоохон хойшилж, саарсан байгаа. Уг нь бас 1 чухал асуудал бол Орос, Хятад 2 улсыг холбосон тийм 2 босоо төмөр замтай больё гэж байгаа. Монгол улс ганцхан төмөр замын коридортой. Алтанбулаг-Улаанбаатар, Замын-Үүд коридортой байгаа бол бид нар бас Бичигт-Чойбалсан-Эрээнцав нөгөө талдаа болохоор нөгөө Шивээхүрэ Улиастай хойд талын боомт нь юу билээ. Хойд талд нь байдаг нөгөө Оросын боомт Тувагийн ингээд холбох ийм 2 коридорыг хийх ийм томоохон төслүүд жоохон удаашралтай явж байна. Гэхдээ .../минут дуусав/

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон уу. 2 дугаар микрофон.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга Мөнгөнсүх. Гишүүний асуултад хариулъя. Энэ удаагийн таван жилийн үндсэн чиглэлийн төслийн 1 гол бодлогын чухал бодлогын хүрээ нь бол шинжлэх ухаан, технологи, хиймэл оюунтай холбоотой бодлогын хүрээ маань байж байгаа. Түрүүн дурдсан үр дүнгийн нөлөөллийн уялдаагаар ингээд авч үзэх юм бол байгаль орчны дараа энэ хиймэл оюунтай холбоотой үр дүнгүүд маань бусад үр дүнгүүддээ хүчтэй эерэг нөлөөлөл үзүүлэх ийм байдлаар шинжилгээ бол гарч ирж байгаа.

Таны асуусан Засгийн газрын үр дүнтэй холбоотойгоор хиймэл оюун ямар үр дүн үзүүлэх вэ гэдэг дээр 2 байдлаар бол үр дүн тодорхойлогдож, шалгуур үзүүлэлт туссан.

Нэгдүгээрт нь, 10.2.1 дээр байгаа Засгийн газрын хиймэл оюуны бэлэн байдлын индексээр хэмжих ийм үзүүлэлт. Хиймэл оюуны зах зээлд .../минут дуусав/

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон гүйцээгээд хариулъя.

Б.Мөнгөнсүх: Хиймэл оюуны зах зээлд өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх,

Хоёрдугаар үр дүн бол хиймэл оюуны зөв хэрэглээг нэмэгдүүлэх буюу шалгуур үзүүлэлт дээр хиймэл оюуны ёс зүйн бэлэн байдлын үзүүлэлтүүдээр хэмжих ийм 2 үр дүн тусгагдсан байгаа. Энэ үр дүнгүүд дээр бол цаашлаад жилийн төлөвлөгөө дээр хийгдэх төсөл, арга хэмжээ маань нэг бүрчлэн төлөвлөгдөөд, ингээд үр дүнгүүд маань хэрэгжээд явах ёстой байгаа.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье. Тодруулъя.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

С.Эрдэнэболд: Одоо Өрсөлдөх чадварын хүрээлэн тайлан гаргаж байгаа. Тэгээд эднийхээс манай улсад удаа дараа өгөөд байгаа 1 том зөвлөгөө ч гэх юм уу, сануулга нь болохоор Монгол Улсын хөгжлийг хойш нь татаж байгаа, хурдасгах боломжийг удаашруулж байгаа үндсэн 5 хүчин зүйл байгаагийн 1-д засаглал өөрөө ороод байгаа юм. Засаглалын хүртээмж муутай, үр өгөөж муутай, данхар, үрэлгэн бүтэц нь өөрөө Монголын хөгжлийг удаашруулж байгаа юм.

Эндээс 2-т нь жишээлбэл одоо эрчим хүчний талбар харагдаж байгаа юм л даа. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ засаглалын үр өгөөжтэй байдал чинь шууд утгаараа нөгөө Transparency International авлигын зөвлөгөө эд нартайгаа шууд холбогдчихоод байгаа юм. Тэгэхээр аль болох одоо жишээлбэл таван жилийн төлөвлөгөө ярьж байхад уг нь технологи 6 сарын хурдаар хөгждөг байсан. Одоо болохоор 2 сарын хурдаар AI хөгжөөд байгаа учраас үүнтэйгээ л уялдуулаарай л гэж Мөнгөнсүх дарга аа, бодлогоо уялдуулаарай л гэж хэлээд байгаа юм шүү. Дараа дараагийн .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа. Би цөөн хэдэн зүйл хэлнэ.

Нэгдүгээрт. Бямбацогт сайд юу яагаарай. Манай энэ гишүүдийн бас хэлж байгаа зүйл бол нөгөө сайд нар нь бүрэн орж ирдэг байх ёстой. Яагаад гэвэл Засгийн газрын нээрээ л чухал асуудал. Бид нар таван жилийнх нь юуг ярьж байна. Манай Байнгын хорооны гишүүд сайд нар нь яагаад орж ирэхгүй байгаа юм бэ гэдэг асуудал яриад байгаа нь бас зүй ёсны юм. Тэгээд өнөөдөр яах вэ, 2 Байнгын хороо яалт ч үгүй ингээд давхацчихсан болохлоор бид нар ойлгож хүлээж авч байна. Цаашдаа бол бас Байнгын хороонд хүндэтгэлтэй хандаарай гэж гишүүдийн хэлж байгааг та нар маань анхаараад үзчихээрэй. Холбогдох сайд нар орж ирэх ёстой.

Хоёрт, Тэмүүжин гишүүний түрүүний тэр ярьж байгаа зүйл их чухал шүү. 2050 он хүртэл гээд бид нар ийм ардчилсан сонгуульгүй орон юм шиг, тэгээд энд нь таараагүй бол яг үнэн энэ Сонгуулийн ерөнхий хороо дээр нөгөө хөтөлбөрийг нь хүлээж авахгүй байна энэ тэр гэдэг бол өөрөө эрх зүйн хувьд Үндсэн хуулийг ноцтой зөрчиж байгаа шүү. Энийг манайхан бодож үзэхгүй бол өөр нам, өөр намын баталсан хэдэн жилийн юуг заавал дагаж мөрдөх ёсгүй. Ард түмэн сонголтоо өөрчилснөөр энэ чинь таалагдахгүй байна. Энийгээ өөрчил гэдэг захиалгыг өгч байгаа учраас энийг бид нар бас эрх зүйн үүднээс нь бодож үзэх ёстой.

Мэдээжийн хэрэг засаглаж байгаа нам бол өмнөх засгийнхаа тэр 2050 он хүртэл бодлогоо хэрэгжүүлэх боломжтой үедээ дуустлаа, эцсээ хүртэл хэрэгжүүлэх гээд явах нь бол зөв.

Энэ дээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тухай нэлээн яриад байна. Би энэ дээр яг тодорхой юмыг яримаар байна. Энэ миний гарт байж байна. 2022 оны 1 дүгээр сард төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг 1-ийг ч нэмж байгуулахгүй гэдэг санаачилга гаргаад, гишүүддээ уриалга гаргаж байгаад энэ материалыг бүрдүүлээд оруулж ирж байсан юм. Тэр үед өнөөдөр гишүүд маань бол Их Хурлаараа бүгдээрээ ярьдаг болсонд би маш их баяртай байгаа. Тэр үед ийм юм ярьж болдоггүй байсан. Хүмүүс ерөнхий тэр үеийн уур амьсгал одоо би тэрийг хэлж байх үед яг ковидын үед нөгөө шилэн хорго шиг юманд сууж байгаад би Их Хурлын даргад энэ саналыг гаргаж байсан. Занданшатар дарга харин яг дэмжээд,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

энийг явуулж байсан юм. Тэр үед байна шүү дээ. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд муу гэж ер нь хэн хэлээд байгаа юм. Харин төрийн өмчит аж ахуйн нэгжүүд чинь ёстой ард түмний баялгийг төлөөлж байна гээд хэн ч ийм юм ярьдаггүй байсан үе байхгүй юу. Та нар бүгдээрээ архивын материалаа сөхөөд үзээрэй. Тэгээд өнөөдөр энэ бүгдийн ярьдаг яриа болчихсон байгаа энэ бол маш зөв. Монгол Улс өөрөө тэр зөв юу руугаа явж байна гэсэн үг.

Тэгэхдээ би энэ дээр зүйл хэлмээр байна. Бямбацогт сайд аа, та хэд маань засаг дээрээ 1 юмыг анхаараарай. Одоо ингээд юу яаж байна шүү дээ. Энэ гол үзүүлэлтүүдээ ярьж байхдаа төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өгөөжийг ийм болгоно, зардлыг нь ингэж буулгана гээд энд засаг дээр бид нар төлөөлөөд, төлөвлөөд яриад байгаа байхгүй юу. Миний хамгийн болгоомжлоод байгаа юм чинь энэ байхгүй юу. Сайд, дарга нар компанийн ажиллагааг ямар байхыг энэ чинь төлөвлөж байгаа юм шиг таван жилийн төлөвлөгөө шиг юм яриад байна. Уг нь компаниудын шийдвэр ТУЗ дээрээ гарч байх ёстой. Яагаад гэвэл зах зээл яаж өөрчлөгдөхийг бид нар яаж мэдээд байгаа юм бэ. Одоо энэ “Эрдэнэс Тавантолгой” юм уу, “Оюутолгой” дэлхийн том зах зээлийн хөдлөлт хаашаа гарч, түүхий эдийн зардал хаашаа эргэхийг бид нар мэдэхгүй шүү дээ. Тэгэхээр тэрийг олборлоход гарч байгаа зардал жишээлбэл бензиний үнэ хаашаа явахыг л бид нар мэдэхгүй байхад зардлыг тэгж буулгана гээд бид нар энд дарга нар шийдээд суугаад байна гэдэг бол жинхэнэ нөгөө миний энэ чинь л болохгүй шүү гэж яриад байгаа юм чинь одоо энэ бичиг баримт дээр тусаж орж ирсээр байгаа манайхан бас энэ бодлогоо боловсруулахдаа анхаараарай гэж хэлмээр байгаа юм.

Тэгээд зүгээр би Байнгын хорооныхондоо харин хандаад 1 зүйл хэлмээр байна. Энэ сая ингэсэн шүү. Энэ ахиад л төсөвтэй холбоотой таван жилийн бид нарын төлөвлөж байгаа, төсөөлж байгаа юм ярьж байгаа учраас сая төсвийн асуудал хэлэлцэгдэхэд манай Байнгын хороо өөрөө өөрийнхөө асуудлыг унагааж байна шүү. Сая ёстой зовж байж өөрийнхөө Байнгын хорооны хэдхэн л асуудлыг төсөвтөө оруулж байна. Тэгэхэд бусад Байнгын хороодын гишүүд бүр толгойд байхгүй тоогоор нэмэгдүүлэх гээд яваад байгаа. Тэр нь зөв, буруугийн тухай асуудал биш. Гэхдээ хүмүүс салбарынхаа төлөө тэгж сэтгэл гаргаж байна шүү дээ.

Тэгэхэд манай энэ Байнгын хороо, бид нар өөрийнхөө салбарыг энэ хүн хүмүүс чинь өөрийнхөө цалинг нэмээд өг гээгүй. Ажлаа хийе. Ажил хийх боломж олгоод өгөөч гээд төсвөө оруулаад ирэхэд нь бид нар энд сууж байгаад тэр төсвийг нь унагаагаад өгч байна гэдэг чинь тэр сэтгэл рүү нь, энэ салбар луугаа нулимж байгаа хэрэг шүү дээ. Тэгэхээр ийм юмыг хэдүүлээ тал талдаа бодож ажилламаар байна. Өөрийнхөө салбарын төсвийг бид нар дэмжээд, нэмээд явахын төлөө л явж байх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа шүү.

5 дугаар микрофон Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Цогтбаатар дарга сая бас зөв асуудал хөндлөө. Тэгээд төрийн өмчит компаниудын засаглалын талаар бид засаглалыг ил тод болгоё, нээлттэй болгоё, улам сайжруулъя гэж байгаа. Тэгээд төрийн өмчит компаниудынхаа үр ашиггүй, үр өгөөжгүй хөрөнгийг бид нар хувьчилъя. Илүү хувийн хэвшлийн оролцоотой болгоё, ингэж үр өгөөжийг нь нэмэгдүүлье гэж байгаа. Зайлшгүй төр ачаа үүрэх, хариуцах ёстой нийгмийн хариуцлагын компаниуд байж байгаа. Одоо эрчим хүчний компаниуд дээр үнэ хатуу бариад байж байна. Энэ зам засвар арчлалтын компаниуд дээр өвөл нь цас орох вий, халтиргаа гулгаа үүсэх вий,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

замынхаа цасаа цэвэрлэ, халтиргаа гулгаа үүсгэхгүй бай. Зунд нь замынхаа цоорхойг нөхөх гээд ингээд үүрэг хүлээлгээд байж байгаа. Ийм компаниудыг нийгмийн хариуцлагын хүрээнд гарцаа байхгүй стратегийн ач холбогдол бүхий салбарт бас Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт гээд компаниудаа бид өөрсдөө илүү ажиллуулах гэсэн ийм бодлого барьж байгаа. Энэ ялгаануудаа бас их тодорхой болгочихмоор байгаа юм. Энэ дээр яг гарцаа байхгүй энэ илүүдэл хөрөнгө, үр өгөөжгүй хөрөнгөө сайжруулъя гэдэг дээр энийгээ яая.

Хавтгайдаа төрийн өмчит компаниуд юугүй байна вэ гэх юм бол бас тийм биш байна. Өнөөдөр Эрдэнэт үйлдвэр, Оюутолгойтой харьцуулахад харьцуулахад яг 1 тонн зэсийн баяжмалд төлж байгаа татвар нь 3 дахин өндөр татвар төлж байна. Өгөөж өгч байна. Эрдэнэс Тавантолгой бусад нүүрсний компаниудтай харьцуулахад яг 1 сая тонн нүүрс гаргасан нүүрсэндээ таарсан татварыг үзэх юм бол нөгөө хувийн компаниудаас 2 дахин өндөр татвар төлж байна. Улсын төсөвт орлого оруулж байна. Өгөөжөө өгч байгаа. Тийм болохоор бүгдээрээ тийм өгөөжгүй байгаа юм биш. Өгөөжтэй компаниудаа илүү сайжруулах, өгөөжөө нэмэгдүүлэх ийм л бодлого барьж байгаа. Монгол Улсын Засгийн газар энэ томоохон компаниудын компаниудын хувьцааг эзэмшдэг. Хувьцаа эзэмшигчийн хувьд ТУЗ-ийг нь томилдог. Гүйцэтгэх удирдлагууд нь компаниуд дээр гүйцэтгэх удирдлагаа зохион байгуулдаг. Тийм үүднээсээ Засгийн газар өнөөдөр энэ төрийн өмчийн компаниудын бодлогыг хувьцаа эзэмшигчийн хувиар оруулж байгаа. Хувийн компани дээр ч гэсэн хувьцаа эзэмшигч өөрийнхөө хөрөнгийг өгөөжийг хэрхэн яаж нэмэгдүүлэх вэ, зардлаа яаж бууруулах вэ гэдэг бодлого тодорхойлж, түүнийгээ ТУЗ-өөр дамжуулаад, ТУЗ-тэй чиглэл өгөөд, ТУЗ нь цааш нь гүйцэтгэх удирдлагуудтай гэрээ хийгээд ингэж хэрэгжүүлдэг. Яг үүнтэй адилхан зарчмаар Засгийн газар хувьцаа эзэмшигч “Эрдэнэс Монгол” компани ТУЗ-ийг нь томилдог. Цаашаагаа гүйцэтгэх удирдлагууд нь ажлыг нь хэрэгжүүлдэг ийм байдлаар Засгийн газар хувьцаа эзэмшигчийн хувиар л оролцоод, бодлогыг нь тодорхойлоод явж байгаа.

2026-2030 оны үндсэн чиглэл дээр бол хөрөнгийн өгөөжийг 14 хувиар нэмэгдүүлж гэж байгаа. 2026 оны төлөвлөгөө дээр болохоор түрүүн Номинчимэг гишүүн асуугаад байсан. Төлөвлөгөөнд орохоор бид нар бүтээмжийг нь 30 хувиар нэмэгдүүлж. Зардлыг нь 15 хувиар бууруулъя гэж байгаа юм. Ингэхээр үндсэндээ богино хугацааны төлөвлөлт дээр илүү нарийвчилсан. Таван жилийн үндсэн чиглэл дээр илүү ерөнхий өгөөж гэдэг агуулгаараа ингэж ялгаатай орж ирсэн байгаа. Тэгээд ажлын хэсэг маань бас Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад бас сайн саналууд гараад, илүү энэ төлөвлөгөө маань, үндсэн чиглэл маань сайжраад явна гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Бямбацогт сайд баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Одонтуяа гишүүнээс зарчмын зөрүүтэй санал гарсан байгаа. Тэгээд ингээд Одонтуяа гишүүний саналыг би уншаад танилцуулчихъя.

1.Төслийн 2, 3 дугаар хавсралтад дор дурдсан агуулгатай 4.2.5.5 дахь дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын Үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын чиглэлийн “Дугаар баганад

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

4.2.5.5” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.2” гэж, “Салбар” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн баганад “Мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлт буурч, иргэдийн хор уршгийн талаарх мэдлэг, боловсрол нэмэгдэж, урьдчилан сэргийлэх зан үйл төлөвшиж, хэрэглэгчдийн тоо мэдэгдэхүйц багасна” гэж, “Арга зам” баганад “Илрүүлэх, шинжилгээний чадавхыг сайжруулж, лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хилийн боомтын хяналт шалгалтыг бэхжүүлж, илрүүлэх төхөөрөмж суурилуулах, хууль бус эргэлтийн мэдээллийн системийг сайжруулж, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай болгох, иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх сурталчилгаа зохион байгуулах, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх.” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам” гэж, 3 дугаар хавсралтын “Үндсэн чиглэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын чиглэлийн дугаар” баганад “4.2.5.5” гэж, “Салбар” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн” баганад “Мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлт буурч, иргэдийн хор уршгийн талаарх мэдлэг, боловсрол нэмэгдэж, урьдчилан сэргийлэх зан үйл төлөвшиж, хэрэглэгчдийн тоо мэдэгдэхүйц багасна” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Тус гэмт хэрэгт холбогдож буй хүний тоо” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026:Т-10%, 2027: Т-20%, 2028: Т-30%, 2029: Т-40%, 2030: он Т-50%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын статистик”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж өөрчилье гэсэн ийм санал орж ирж байна. Нэмэх санал орж ирж байна.

Ингээд санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа. Саяын уншиж юу уншсан томъёоллоор санал хураалт явуулъя. Энийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Эхлээд гишүүд санал хураалтдаа бэлтгэе. 64.4 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг баталлаа.

Байнгын хороо энэ хуралдаанаар хэлэлцэх асуудлаа дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө. Энэ тогтоолыг Соронзонболд гишүүн Эдийн засгийн байнгын хороонд танилцуулна шүү. Өнөөдөр 4 цагаас гэж байсан. Ингээд хурал дууслаа. Гишүүддээ баярлалаа.

12.48 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ